



# ЖИЛИЙН ТАЙЛАН 2011



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ТАНЫ БИЗНЕСИЙН  
НАЙДВАРТАЙ ТУНШ

# АГУУЛГА

- |    |  |
|----|--|
| 4  | Ерөнхийлөгчийн илгээлт   |
| 6  | Санхүүгийн үзүүлэлтүүд   |
| 10 | Гүйцэтгэх захирлын илгээлт   |
| 12 | Эрхэм зорилго  |
| 13 | Эдийн засгийн болон банкны салбарын тойм,<br>2012 оны эдийн засгийн хэтийн төлөв |
| 16 | ХХБ-ны 2012 оны стратеги төлөвлөлт ба зорилтууд                                  |
| 16 | Банкны танилцуулга, гол үзүүлэлтүүд  |
| 17 | Бизнесийн танилцуулга  |
| 18 | Компанийн засаглал   |
| 19 | Үйл ажиллагааны бүтэц  |
| 20 | Компанийн засаглалын бүтэц   |
| 20 | ТУЗ, Захирлын зөвлөл   |
| 22 | Удирдлагын баг   |
| 24 | 2011 оны онцлох үйл явдлууд  |
| 25 | Амжилтын товчоон   |
| 26 | Бизнесийн үйл ажиллагаа  |
| 28 | Байгууллагын банкны үйл ажиллагаа  |
| 32 | Иргэдийн банкны үйл ажиллагаа  |
| 36 | Картын бизнесийн үйл ажиллагаа   |
| 42 | Гадаад харилцааны банкны үйл ажиллагаа   |
| 47 | Тидиби Капитал   |
| 53 | Хөрөнгө зохицуулалтын удирдлага  |
| 56 | Эрсдэлийн удирдлага  |
| 67 | Мэдээллийн технологи   |
| 69 | Хүний нөөцийн удирдлага  |
| 72 | Хамт олны амжилт, ололтууд   |
| 73 | Нийгмийн хариуцлага  |
| 74 | Ностро данстай банкууд   |
| 75 | Хамтын санхүүжилтээр харилцагч банкууд   |

- TDB IS THE LARGEST CORPORATE LENDER IN MONGOLIA, WITH A BROAD KNOWLEDGE AND EXPERTISE OF ECONOMIC SECTORS.
- TDB IS THE MOST REPUTABLE INTERNATIONAL BANK OF MONGOLIA AND THE FIRST MONGOLIAN COMPANY TO ISSUE BONDS IN THE INTERNATIONAL CAPITAL MARKETS WITHIN USD 700 MILLION EMTN PROGRAM.
- TDB IS PLAYING A LEADING ROLE IN ARRANGING FACILITIES FOR MANY SIGNIFICANT MINING PROJECTS IN MONGOLIA.



## LARGEST CORPORATE LENDER IN MONGOLIA

- Corporate finance
- Equipment loan
- Investment loan
- Working capital
- Leasing
- Syndicated loan
- Trade finance
- Project finance
- Real estate and commercial mortgage



Together towards prosperity

Tel: +976 11 312362, 1977 | Fax: +976 11 327028, 331155  
E-mail: [info@tdbm.mn](mailto:info@tdbm.mn) | Web: [www.tdbm.mn](http://www.tdbm.mn)

# ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИЛГЭЭЛТ



“ 2011 он нь Монгол Улсын хувьд эдийн засгийн хурдацтай хөгжлийн жил байсан ба 2010 онд 6.4 хувьтай байсан ДНБ 2011 онд 17.3 хувьд хүрсэн нь түүхэнд байгаагүй үзүүлэлт болсон юм. Түүнчлэн 2010 онд 13 хувьтай байсан ажилгүйдлийн түвшин 9 хувь болж буурсан нь бас нэгэн зэрэг үзүүлэлт байлаа. ”

## Эрхэм харилцагч, хамтран ажиллагч түншүүд, ноёд хатагтай нар аа,

Монгол Улсын эдийн засаг хурдацтай хөгжжик байгаа энэ цаг үед Худалдаа, хөгжлийн банк 2011 оны өөрийн үйл ажиллагааны, ололт амжилт, санхүүгийн тайлан үзүүлэлтээ Та бүхэнд танилцуулж байгаадаа таатай байна.

2011 он нь Монгол Улсын хувьд эдийн засгийн хурдацтай хөгжлийн жил байсан ба 2010 онд 6.4 хувьтай байсан ДНБ 2011 онд 17.3 хувьд хүрсэн нь түүхэнд байгаагүй үзүүлэлт болсон юм. Түүнчлэн 2010 онд 13 хувьтай байсан ажилгүйдлийн түвшин 9 хувь болж буурсан нь бас нэгэн зэрэг үзүүлэлт байлаа.

Энэхүү эдийн засгийн өндөр өсөлт нь уул уурхайн салбарын хурдацтай хөгжил болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын өндөр өсөлттэй салшгүй холбоотой юм.

Мөн 2011 онд Монгол Улсын гүйлгээнд байгаа мөнгөний нийлүүлэлт өмнөх оноос 37.3 хувиар, банкны салбарын нийт олгосон зээл 72 хувиар тус тус өссөн бол татан төвлөрүүлсэн хөрөнгө 2010 онтой харьцуулахад 36.5 хувиар өссөн таатай үзүүлэлтүүдээр арвин жил байв.

Түүнчлэн 2011 онд Монголын банкны салбарын нийт актив 9.4 их наяд төгрөг болж нийт ДНБ-ний 86 орчим хувийг бүрдүүлж байгаа нь Монголын банк санхүүгийн салбарын хүчтэй байр суурийг илтгэсэн томоохон үзүүлэлт юм. Мөн тус онд банкны салбарын хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 11.9 хувиар буурсан нь бас нэгэн зэрэг үзүүлэлт байлаа.

ХХБ-ны хувьд 2011 оны санхүүгийн жил онцгой амжилтаар дүүрэн жил байсан бөгөөд банкны нийт активын хэмжээ 2090.0 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгийн хэмжээ 139.4 тэрбум төгрөгт хүрсэн ба татварын дараах нийт ашиг 42.1 тэрбум төгрөгт хүрэн өслөө.

Бид олон улсын зах зээл дээр 2007, 2010 онуудад Монголын арилжааны банкууд болон аж ахуйн нэгжүүдээс хамгийн анх удаа бонд гарган амжилттай арилжаалсан явдал нь Худалдаа, хөгжлийн банкны тогтвортой үйл ажиллагаа, нэр хүндийг олон улсын зах зээлд таниулсан томоохон үйл явдал болсон юм. Улмаар манай банк олон улсын нэр хүнд бүхий томоохон байгууллагуудтай өөрийн хамтын ажиллагааны харилцаагаа өргөжүүлсээр байна.

Үүний нэг томоохон жишээ нь 2011 онд Худалдаа, хөгжлийн банк АНУ-ын Блуүмбэрг компанийт хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурж, улмаар Блуүмбэрг телевизийн сувгийг албан ёсны орчуулгатайгаар нэвтрүүлэх болон дотоодын санхүү, эдийн засгийн үйл явдалд үндэслэсэн мэдээ, мэдээллүүдийг бэлтгэн цацахаар Ти Ди Би Медиа ХХК-ийг байгуулан ажиллаж байна.

Энэхүү үйл явдал нь Монгол Улсын эдийн засаг хурдацтай хөгжжик байгаатай уялдан дэлхийн олон орны хөрөнгө оруулагчид манай улсын эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагад өндөр анхаарал хандуулж байгаа энэ цаг үед цагаа олсон томоохон алхам болсон билээ.


2011 онд Худалдаа Хөгжлийн банк нь 150 гаруй олон улсын харилцаагаа өргөжүүлэх тал дээр тулхүү анхаарч, Хятадын банкны Хонг Конг дахь салбар (Bank of China, Hong Kong Branch), ВТБ Москва (VTB Moscow), CITI Bank, Unicredit Moscow банк, Renaissance Securities зэрэг банк санхүүгийн байгууллагуудтай харилцан данс нээж, Хятадын Хөдөө аж ахуйн банк (Agricultural Bank of China), Бугат хотын арилжааны банк (Baoshang Bank)-уудтай импортын санхүүжилтийн гэрээ, ХБНГУ-ын Commerzbank-тай “Худалдааны санхүүжилтийн мастер гэрээ” гэрээнд тус тус гарын үсэг зурж, Хятад болон Европын холбооны улсууд төдийгүй бусад улсуудаас хийж буй импортын санхүүжүүлэх боломжийг нэмэгдүүллээ. 2011 онд ХХБ Монгол улсын гадаад худалдааны төлбөр тооцооны 48 хувийг дангаараа гүйцэтгэсэн ба олон улсын стандартад нийцсэн банкны цогц үйлчилгээг хүргэдэг нь бидний давуу тал юм.

Мөн 2011 оны томоохон онцлоо үйл явдлуудын нэг нь ХХБ өөрийн охин компани болох Ти Ди Би Капитал ХХК-ийг үүсгэн байгуулсан явдал юм. Монгол Улсын эдийн засгийн хурдацтай өсөлт, уул уурхайн салбарын хөгжилтэй уялдан Монгол Улсын иргэн бүр эх орныхоо баялгаас хувь хүртэх боломжтой болж буй энэ үед Ти Ди Би Капитал ХХК нь Худалдаа, хөгжлийн банкны 20 гаруй жилийн хугацаанд хуримтлуулсан туршлага, олон улсын банк санхүүгийн зах зээл дээрх нэр хүнд, харилцаа холбоо болон дотоодын зах зээл дээрх тэргүүлэх байр сууринд тулгуурлан Монгол Улсын хөрөнгийн зах зээлд өөрийн бодит хувь нэмрийг оруулахаар үйл ажиллагаагаа эхлүүллээ.

Бидний амжилт, ололтын түүхэн цаг үед бидэнтэй хамт байж үнэнчээр дэмжиж ирсэн нийт харилцааг, хадгаламж эзэмшигчид, гадаад, дотоодын түншүүдээ халуун талархал илэрхийлье.

Худалдаа, хөгжлийн банк болон Монгол Улсын хувьд ирж буй 2012 он ололт амжилтаар дүүрэн бас нэгэн онцгой жил болно гэдэгт бид итгэлтэй байна.

Монголын арилжааны ууган банк болох Худалдаа, хөгжлийн банк өөрийн 20 гаруй жилийн арвин их туршлагаараа таны ирээдүйн санхүүгийн найдвартай түвш байсаар байх болно, Харилцааг та бүхний бизнесийн ашиг орлого өөдөө, амьдрал тань улам цэцэглэн хөгжихийг хүсэн ерөөе.



Рандолф Коппа  
Ерөнхийлөгч

# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	тэрбум төг				
	2011	2010	2009	2008	2007
<b>Актив:</b>					
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	475.0	553.5	267.0	140.8	110.4
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	350.0	260.7	90.3	38.8	46.4
Зээл ба урьдчилгаа (цэвэр)	1,123.3	464.5	406.2	440.3	382.3
Буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаас	37.0	0.0	0.8	0.0	0.0
Хоёрдогч зээл	7.0	7.0	7.0	4.0	4.0
Үндсэн хөрөнгө	79.1	19.8	21.4	21.8	11.7
Биет бус хөрөнгө	0.4	0.7	0.8	1.0	1.0
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	0.6	1.0	2.1	0.3	0.6
Бусад актив	17.6	31.8	14.7	12.3	7.1
<b>Нийт актив</b>	<b>2,090.0</b>	<b>1,338.9</b>	<b>810.4</b>	<b>659.3</b>	<b>563.5</b>
<b>Пассив:</b>					
Харилцагчдын харилцах, хадгаламж	1,277.3	919.9	579.5	374.5	373.0
Банк, бусад санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	206.5	53.6	31.5	33.5	15.3
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	174.4	50.7	53.3	59.0	7.4
Татварын өглөг	1.5	1.5	1.3	0.5	1.5
Гаргасан өрийн бичиг	207.1	173.3	59.6	94.5	86.7
Бусад пассив	42.1	20.4	17.9	18.7	10.1
Хоёрдогч өглөг	41.7	31.2	0.0	10.1	9.4
<b>Нийт өр төлбөр</b>	<b>1,950.6</b>	<b>1,250.6</b>	<b>743.2</b>	<b>590.8</b>	<b>503.2</b>
Хувьцаат капитал	8.0	8.0	7.5	7.5	8.2
Бусад өмч	22.4	13.4	13.7	13.7	4.8
Хуримтлагдсан ашиг	109.0	66.9	45.9	47.3	47.3
Нийт өөрийн хөрөнгө	139.4	88.3	67.1	68.5	60.3
<b>Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө</b>	<b>2,090.0</b>	<b>1,338.9</b>	<b>810.4</b>	<b>659.3</b>	<b>563.5</b>



## Орлогын тайлан

тэрбум төг

	2011	2010	2009	2008	2007
Хүүний орлого	143.5	89.2	77.3	71.2	47.3
Хүүний зардал	(95.4)	(60.1)	(45.7)	(33.6)	(26.7)
Хүүний цэвэр орлого	48.1	29.1	31.6	37.6	20.6
Хураамж, шимтгэлийн цэвэр орлого	12.1	6.9	6.1	7.0	6.3
Үйл ажиллагааны бусад орлого (зардал)	14.3	9.3	6.1	(7.0)	4.1
Хүүний бус цэвэр орлого	26.4	16.1	12.1	0.0	10.4
Үйл ажиллагааны орлого	74.5	45.3	43.7	37.6	31.1
Үйл ажиллагааны зардал	(20.1)	(18.6)	(17.7)	(15.9)	(13.7)
Болзошгүй эрсдэлийн зардал	(3.1)	(1.7)	(8.4)	(1.8)	2.6
Татварын өмнөх ашиг	51.4	25.0	17.6	19.9	19.9
Орлогын татварын зардал	(9.3)	(4.3)	(2.6)	(3.6)	(3.6)
Тухайн жилийн цэвэр ашиг	42.1	20.7	15.0	16.3	16.4


тэрбум төг


	2011	2010	2009	2008	2007
Ашигт ажиллагаа					
Зардлын орлогод эзлэх хувь	26.9%	41.0%	40.5%	42.2%	44.1%
Цэвэр хүүгийн зөрүү	3.5%	3.3%	4.1%	5.8%	4.5%
Өөрийн хөрөнгийн өгөөж	30.2%	23.4%	22.3%	23.8%	27.2%
Активын өгөөж	2.0%	1.5%	1.8%	2.5%	2.9%
Өсөлтийн харьцаанууд					
Активын өсөлт	56.1%	65.2%	22.9%	17.0%	32.2%
Зээлийн өсөлт	141.9%	14.3%	-7.7%	15.2%	59.2%
Харилцах, хадгаламжийн өсөлт	38.8%	58.7%	54.8%	0.4%	14.9%
Өөрийн хөрөнгийн өсөлт	57.9%	31.5%	-2.0%	13.7%	21.3%
Актив, активын чанар					
Зээл/Харилцах, хадгаламж	89.3%	52.0%	72.7%	117.6%	102.5%
Зээлийн активт эзлэх хувь	53.7%	34.7%	50.1%	66.8%	67.8%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	43.0%	67.0%	47.0%	37.0%	26.0%
Өөрийн хөрөнгийн харьцаа:					
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ	8.2%	10.2%	10.1%	10.2%	11.0%
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	12.7%	16.3%	12.7%	14.7%	13.8%

2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр цэвэр зээлийн үлдэгдэл 1,123.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 658.9 тэрбум төгрөг буюу 141.9 %-аар өссөн байна. Энэ нь 2010 оны сүүлээр банкны эх үүсвэр өндөрөөр нэмэгдэж, 2011 онд ч эх үүсвэрийн өсөлт өндөр байсантай холбогдуулан банк 2011 онд зээлийн багцыг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажилласантай холбоотой. Түүнчлэн 2011 онд олон салбар, тооцооны төвүүдийг шинээр нээсэн нь зээлийн багц нэмэгдэхэд нөлөөлсөн.

Нийт пассив, өөрийн хөрөнгийн хэмжээ 2,090.0 тэрбум төгрөг болж өмнөх оны эцсээс 751.2 тэрбум төгрөг буюу 56.1 хувиар өсчээ. Нийт пассив, өөрийн хөрөнгөд нийт харилцах, хадгаламж 61.1%, банкны харилцах, хадгаламж 9.9 %, банкнаас авсан зээл 8.3 %, бонд 9.9%, бусад пассив 2.0 % мөн өөрийн хөрөнгө 6.7 %-ийг тус тус эзлэж байна.

Цэвэр ашиг 42.1 тэрбум төгрөгт хүрч 2010 оны эцэстэй харьцуулхад 21.4 тэрбум төгрөг буюу 103.4 %-аар өссөн байна. Зээлийн багцын огцом өсөлт нь зээлийн хүүний орлогыг 2010 оны эцсээс 54.3 тэрбум төгрөгөөр буюу 60.9 хувиар өсгөжээ. Мөн тухайн тайлант хугацаанд хүүний бус цэвэр орлого 26.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөн зах зээлийн өсөлттэй холбоотойгоор шимтгэлийн орлогын өсөлт ч өндөр байлаа.





# THE WORLD IS HEADING TO MONGOLIA ...

... to profit from vast opportunities in one of the fastest growing economies in the world, fueled by its massive mining projects.

Trade and Development Bank of Mongolia, the country's premier corporate and international bank, the first Mongolian issuer of bonds on the international capital markets, is here to cooperate with you to meet your investment goals.

Your inevitable business partner in Mongolia, Trade and Development Bank of Mongolia.

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ИЛГЭЭЛТ



“2011 онд Худалдаа, хөгжлийн банк Монгол Улсын тэргүүлэх банкны байр сууриа хадгалж, нийт цэвэр ашгийн хэмжээ оны эцсийн байдлаар 42.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 103.4 хувиар өссөн амжилт гаргажээ. Түүнчлэн тус онд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 1,277.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 38.8 хувиар, нийт олгосон зээл 1,123.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 141.8 хувиар, нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 80 мянгад хүрч өмнөх оноос 32 хувиар, нийт харилцагч томоохон аж ахуйн нэгж, корпорациудын тоо 400 гаруй болж өмнөх оноос 15 хувиар тус тус өссөн таатай үзүүлэлттэй байна.”

## Хүндэт харилцагч, бизнесийн түнш, хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагсад аа!

2011 онд Худалдаа, хөгжлийн банк Монгол Улсын тэргүүлэх банкны байр сууриа хадгалж, нийт цэвэр ашгийн хэмжээ оны эцсийн байдлаар 42.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 103.4 хувиар өссөн амжилт гаргажээ. Түүнчлэн тус онд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 1,277.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 38.8 хувиар, нийт олгосон зээл 1,123.3 тэрбум төгрөг болж өмнөх оноос 141.8 хувиар, нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 80 мянганд хүрч өмнөх оноос 32 хувиар, нийт харилцагч томоохон аж ахуйн нэгж, корпорациудын тоо 400 гаруй болж, өмнөх оноос 15 хувиар тус өссөн таатай үзүүлэлттэй байна.

Санхүүгийн хувьд маш сайн үзүүлэлттэй гарсны зэрэгцээ бизнесийн үйл ажиллагаагаа бид тасралтгүй өндөр хэмжээнд хөгжүүллээ. Тухайлбал, Худалдаа, хөгжлийн банк нь зээлийн уян хатан бөгөөд тэлэлтийн бодлогыг баримтлан ажиллаж, харилцагчиддаа хүү, шимтгэлийн хамгийн таатай, зах зээлд өрсөлдөхүйц нөхцөлөөр иргэдийн хувийн хэрэгцээ болон жижиг, дунд бизнесийн хэрэгцээг хангах бүх төрлийн зээлийн үйлчилгээг үзүүлснээр өмнөх оноос зээлийн багцын хэмжээг даруй 3.8 дахин өсгөж, банкны салбарт иргэдийн зээлийн багцын өсслөөрөө тэргүүн эгнээнд бичигдлээ.

Харилцагч аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөтгөхөд ихээхэн идэвх санаачилгатай оролцож, тэдгээрийн бизнесийн онцлогт тохирсон зээлийн бүтээгдэхүүнийг уян хатан нөхцөлтэй олгож, байгууллагад олгосон нийт зээлийн багц 126.0 хувиар өслөе.

Худалдаа, хөгжлийн банк нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл-II, Дэлхийн банкны Хувийн хэвшлийг хөгжүүлэх төсөл-II, Германы KFW болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэртэй дунд хугацааны хөрөнгө оруулалтын зээлийн хөтөлбөрүүдийг амжилттай үргэлжлүүлэн нийт жижиг, дунд зээлийн багцыг 62.5 тэрбум төгрөгт хүргэлээ.

Картын бизнест олон шинэ алхмуудыг хийснээс онцгойлон дурдаад Худалдаа, хөгжлийн банк нь автомашин эзэмшигч иргэд, байгууллагуудад зориулан шатахууны хөнгөлөлтийн "МТ" болон "М-Ойл" шатахууны картудыг зах зээлд нэвтрүүллээ. Мөн өөрийн нэрийн урьдчилсан төлбөрт "Бэлэглэлийн карт"-ыг зах зээлд нэвтрүүлж харилцагчиддаа бэлэг барилаа.

Түүнчлэн гар утсаа ашиглан төлбөр төлөх, гүйлгээ хийх, бэлэн мөнгө авах боломжийг "Most Money" төслийн хүрээнд шийдэж бэлтгэл ажлыг хангалаа. Гар утасны интернэт буюу GPRS технологид суурилсан WAP, JAVA гэсэн 2 хувилбараар Мобайл банкны үйлчилгээг 2011 онд харилцах, хадгаламж, картын данс зээмшигч гэх мэт бүх харилцагчиддаа санал болголоо.

Зах зээлд тэргүүлэгт ууган банкны хувьд Монголын ирээдүй болсон заруучуудыг дэмжих 2011 онд боловсон хүчиний тоогоо 25.9 хувиар нэмж, нийт 380 гаруй ажлын байрыг шинээр бий болгож олон заруучуудыг эгнээндээ нэгтгэж, нийт ажилчдын 80 -аас дээш хувь нь 35 хүртэлх насныхан ажиллаж байна.

Нийслэлийн хүн ам төвлөрсөн бусууддэд нийт 10, Дархан, Эрдэнэт, Хөтөл, Даланзадгад хотуудад 4 салбар, тооцооны төвүүдийг шинээр нээж, харилцагч үйлчилгүүлэгчидээ банкны үйлчилгээг улам ойртууллаа.

Нийгмийн хариуцлагатай тэргүүлэх банкны хувьд нийгмийн сайн сайхан, гэрэлт ирээдүйн төлөө мөнгөн хөрөнгө шаардлагатай нийгмийн бүх давхаргад 1.5 тэрбум төгрөгийн хандив дэмжлэг, ивээн тэтгэлгийг олголоо.

Худалдаа хөгжлийн банкны хувьд үйл ажиллагаа, үйлчилгээний цар хүрээ өндөр хурдацтай өргөжин тэлсэн жил байсан ба уг амжилтанд хүрэхдээ Худалдаа хөгжлийн банктай байнга хамт байж, бидэнд үнэнч байдаг нийт харилцагч иргэд, дотоод гадаадын байгууллага, хамтран ажиллагч бизнесийн түншүүдээ талархал илэрхийлье. Зах зээлд 21 жил тэргүүлж, итгэлийг тань алдаагүй Худалдаа хөгжлийн банк ирэх 2012 онд харилцагчдын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн маш мэдрэмжтэй, уян хатан ажиллаж, бүтээгдэхүүн үйлчилгээг чанаржуулахаас гадна цахим бүтээгдэхүүний дэвшилтэй технологийг харилцагчдад цогцоор хүргэж, зах зээл дэх байр сууриа батжуулан бэхжүүлэх, зах зээлийн хувия нэмэгдүүлэх зорилтыг тавин ажиллах ба таны найдвартай санхүүгийн түнш байсаар байх болно.



Балбарын Мэдрээ  
Гүйцэтгэх захирал

# ЭРХЭМ ЗОРИЛГО

## Эрхэм зорилго

ХХБ нь Монгол улсын олон талт үйл ажиллагаатай, тэргүүлэх зэргийн банкны хувьд том, жижиг дунд, жижиг харилцагчдын зах зээлийн эрэлт хэрэгцээнд үндэслэсэн, үнэ цэнэтэй банкны үйлчилгээг хөгжүүлэн хүргэж, үйлчилгээнээс хүртэх сэтгэл ханамжийг байнга, хамгийн өндөр түвшинд байлгахад зорин ажиллана. Бид бүхний амжилт ололт шилдэг сайн үйлчилгээ, өндөр мэргэжлийн боловсон хүчин, хамтын удирдлагын дээд зэргийн арга барилд үндэслэх болно.

## Хэтийн зорилго

ХХБ нь Монгол улсын банк санхүүгийн зах зээлд тэргүүлэгч, олон улсын шилдэг туршлагуудыг үйл ажиллагаанд даа бүрэн хэрэгжүүлсэн олон талын үйл ажиллагаатай банк, харилцагч үйлчлүүлэгч, хамтрагч түншүүдийнхээ санхүүгийн сайн сайхан, тогтвортой байдалд хүрэхэд тууштай, хариуцлагатай туслагч, итгэл найдварыг нь хүлээсэн түнш нь байсаар байх болно.



# ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ, 2012 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ


## Бодит сектор

2011 онд Монгол улсын эдийн засаг хурдацтай өсч ДНБ-ий бодит өсөлт 17.3%-д хүрсэн нь түүхэнд байгаагүй үзүүлэлт байлаа. Үүнд бүтээгдэхүүний цэвэр татвар 52.2%, бөөний болон жижиглэнгийн худалдаа 42.5% өссөн нь голчлон нөлөөлжээ. Үүнээс хараад эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт, төсвийн зарлага өссентэй холбоотойгоор хэрэглээний өсөлт эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл болжээ. Төсвийн зарлага 2011 онд өмнөх оноос 56 хувиар өсч дотоодын эрэлтийг нэмэгдүүлсэн. Мөн дотоодын банкуудын зээл өмнөх оноос 73%-иар өссөн нь дотоодын эрэлт өндөр байгааг харуулж байна. 2012 онд төсвийн зарлага 32%-иар нэмэгдэхээр өндөр төлөвлөж байна. Эдийн засгийн энэ өндөр өсөлтийн үед мөнгө зээлийн эрэлт буурахгүй, нөгөө талаасаа гадаад зах зээлээс орж ирэх хөрөнгийн ургсал өндөр байх төлөвтэй байна. 2011 онд эдийн засгийн халалтаас сэргийлэх, инфляцийн өсөлтийг хязгаарлахын тулд Монголбанк бодлогоо чанглаж бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн ба дотоод зах зээл дээрх эх үүсвэрийн хэмжээ буурсан, мөн гадаад зах зээлээс татаж буй эх үүсвэрийн хүүгийн түвшин өндөр байгаа тул 2012 онд дотоод зах зээл дэх хүүний түвшин буурахгүй байх хандлагатай байна.


## Төсөв

2012 оны төсвийн тодотголоор төсвийн нийт зарлагыг 6,467 тэрбум төгрөгөөр буюу өмнөх оны төсвөөс 32%-иар өссөн байхаар баталсан. Нийт өсөлтийн 60 хувь нь 428 тэрбум төгрөгийн цалин хөлс, 486 тэрбум төгрөгийн ургсал шилжүүлэг байгаа нь төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр тэтгэмжийг 2 үе шаттайгаар нэмэх шийдвэртэй холбоотой юм. Түүнчлэн 2012 оны төсөвт хөрөнгө оруулалтын төсөв нэлээд өндөр буюу 46 хувийг эзэлж байгаа ба энэ нь Монголын эрдэс баялгийг газрын гүнээс гарган зах зээлд хүргэхэд шаардлагатай авто зам, төмөр замын сүлжээг сайжруулах зорилгоор гаргаж буй 1 тэрбум амдолларын хөрөнгө оруулалтын төсвийг зардалд суулгасантай холбоотой юм. 2012 он бол төсвийн тэлэх бодлогыг баримталсан, ялангуяа цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, халамжийн хэлбэрийн ургсал зардлыг ихээр нэмэгдүүлсэн байгаа нь эдийн засгийн өндөр өсөлтийн үед ажиглагддаг хэт халалтын шинж тэмдгийг нэмэгдүүлдэг талтай.

2012 оны төсвийн зарлагын бүтэц



2012 оны төсвийн өсөлтийн бүтэц



Тэрбум төгрөг

## Уул уурхайн салбар

Монгол улсын уул уурхайн салбар нь ДНБ-д 20%-ийг эзэлдэг ба 2011 онд уг салбарын өсөлт нь 8.7%-тай гарсан байна. 2011 оны сүүлээр уул уурхайн тоног төхөөрөмжийн импорт их хэмжээгээр нэмэгдэн гадаад худалдааны алдагдлыг нэмэгдүүлсэн. 2013 он эхний хагаст Оюу толгой төслийг ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй байгаа ба нийт хөрөнгө оруулалт хийх хэмжээ нь 6 тэрбум ам.доллар байх тооцоо байна. 2011 оны эцэс гэхэд 3.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн бол 2012 онд 2.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөжээ. 2011 оны эхний хагас жилийн байдлаар нийт экспортын 36.9%-ийг нүүрс, 25.2%-ийг зэсийн баяжмал, 9.5%-ийг төмрийн хүдэр эзэлж байгаа ба манай улсын эдийн засгийн өсөлт уул, уурхайн салбараас өндөр хамааралтай байгааг харуулж байна. Манай улсын нийт экспортын 90 гаруй хувийг БНХАУ эзэлж байгаа ба БНХАУ-ын эдийн засгийн өсөлт бодлогын хүрээнд 2012 онд бага зэрэг саарах төлөвтэй байгаа ба энэ нь манай орны уул уурхайн салбар, эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх магадлалтай юм.

Дэлхийн энергийн агентлагаас гаргасан тайлангаас харахад БНХАУ, Энэтхэг зэрэг орнуудын эрчим хүч, нүүрсний эрэлт хэрэгцээ ихээр нэмэгдэх төлөвтэй, дэлхийн нүүрсний хэрэглээ өссөөр 2020 онд 5,850 сая тонн болж тогтвортых хандлагатай болно гэж үзсэн байна. 2010 онд Хятадын нүүрсний хэрэглээ 3.2 тэрбум тонн байсан бөгөөд Хятадын Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооноос нүүрсний хэрэглээг 3.8 тэрбум тонноос ихгүй байлгахаа бодлого баримталж байгаа юм. Үүний хүрээнд 2011-2015 онуудад 5 жилийн төлөвлөгөө батлан хэрэгжүүлээд эхлээд байгаа бөгөөд байгаль орчин халгүй эрчим хүчиний эх үүсвэрийг илүү түлхүү ашиглах талаар төлөвлөгөөнд тусгагджээ.

## Худалдааны салбар

Худалдааны салбар 2010 онд 39.3%-ийн өсөлттэй, 2011 онд 42.5% өсөлттэй гарч он дараалан өндөр хэмжээний өсөлтийг харууллаа. 2011 оны байдлаар бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар ДНБ-ий 11.3%-ийг эзэлж байна. Ялангуяа Монгол улс шиг хэрэглээн дээр суурилсан эдийн засагтай орны хувьд хэрэглээг дэмжсэн төсвийн тэлэх бодлого шиг арга хэмжээнүүд авагдсаар байвал энэ салбарын өсөлт 2012 онд ч өндөр гарах хандлагатай байна.

## Барилгын салбар

Барилгын салбарын хувьд ч өсөлт өндөр байсан төдийгүй оны эцсээр жилийн өсөлт нь 14.3% хүрлээ. Барилгын салбарт моргейжийн зээл гарсанаар дэмжлэг болж өсөлтөнд нөлөөлсөн. Төв банк бодлогын хүүгээ өсгөсөнтэй холбоотойгоор арилжааны банкууд орон сууцны зээлийн хүүгээ өсгөсөн хэдий орон сууцны эрэлт буурах төлөвгүй байна. Засгийн газраас баталсан 100,000 айлын орон сууцны хөтөлбөрийн хүрээнд 6%-ийн хүйтэй орон сууцыг иргэдэд олгож эхлэхээр төлөвлөсөн нь эрэлтийг улам өсгөж байгаа хэдий ч барилга угсралт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх тал дээр тодорхой арга хэмжээ авах үйл явц хоцрогдолтой байгаа тул богино хугацаанд орон сууцны үнэ буурах эсэх нь эргэлзээтэй байна.

## Газрын тос олборлолтын салбар

Статистик мэдээллээс харахад Монгол улсын нийт газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээний нэлээдгүй өндөр хувийг уул уурхайн салбар хэрэглэж байна. Уул уурхайн салбарын эрчимтэй өсөлт нь газрын тосны эрэлтийг ихээхэн нэмэгдүүлэх төлөвтэй байгаа юм.

2012 онд Ираны эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээ, Ойрхи дорнодын үйлдвэрлэлийн сэргэлт, АНУ, Европын улсуудын хэрэглээний бууралт нь түүхий нефтийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийг бууруулах, БНХАУ, Энэтхэгийн эрчим хүчиний хэрэглээний хомсдол нь үнийг өсгөх магадлалтай ба манай улсын нефтийн импортын үнийн түвшинд нөлөө үзүүлэх боломжтой юм.

## Монгол улсын гол экспортын бүтээгдэхүүний үнэ

Алт: Алтны үнэ 2011 онд хамгийн дээд тал нь 1,895 ам.доллар болж хамгийн өндөр түвшинд хүрлээ. Алтын үнэ 2010 оноос хойш тогтмол өссөөр ирсэн. Энэ нь дэлхийн эдийн засгийн эмзэг байдал, ялангуяа доллар, еврод итгэх итгэл багассан тул алтанд хөрөнгөө байршуулж үнэ цэнэ бууралтаас сэргийлэх гэсэн хөрөнгө оруулагчдын эрэлт алтны үнийг дээд хэмжээнд хүргэсэн. Мөн Евро бүсийн өрийн асуудал 2012 оны туршид хэвээр байх нөхцөлд алтны үнэ буурах төлөвгүй байгаа ба энэ нь манай улсын хувьд экспортын орлогыг өсгөх эерэг талтай.

### Зэс


2011 оны 1 ба 2-р саруудад зэсийн үнэ өсч шинэ дээд амжилт тогтоосон боловч 4, 5 саруудад буурсан. Уг шалтгаан нь: Хятад улсын инфляци болон Долларын ханш чангарч байгаатай холбоотой байсан. Хятад улс дахь Зээлийн бодлого чангарсан болон Зэсийн өндөр үнээс болж Хятадын цахилгаан болон кабель зэс утас үйлдвэрлэгчид болон зэс худалдан авагчид худалдан авалтаа зогсоосон нь үнийн бууралтанд гол нөлөө үзүүлсэн. 2011 оны 8 сар хүртэл зэсийн үнэ дахин өсөж эхэлсэн хэдий ч дэлхийн зэсийн хэрэглээний 19%-г бий болгодог Европын хэд хэдэн улсуудын санхүү болон өрийн хямралын байдалтай уялдан 2011 оны сүүлийн саруудад зэсийн борлуулалт зогсонги байдалд орсон. 2012 онд дэлхийн зэсийн хэрэглээ 2,7%-р нэмэгдэнэ гэж тооцож байгаа юм. Зэсийн хэрэглээ 2009-2010 оных шиг хурдтай нэмэгдэхгүй ба зэсийн нийлүүлэлт нилээд хоцорч байгаа тул 2012 онд зэсийн зах зээл дээр хомсдол үүсэх магадлалтай байна. Манай улсын хувьд зэсийн нийлүүлэлтийг боломжит түвшинд хадгалан гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, төсвийн орлогыг өсгөн ажиллах боломжтой юм.

### Банкны салбар

Улсын эдийн засгийн үзүүлэлтүүдтэй зэрэгцэн Банкны салбар 2011 онд мөн өндөр өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив 2011 онд 9.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.1 их наяд төгрөгөөр буюу 50.1%-иар өслөө. Нийт зээлийн багц (цэвэр) онд 5.4 их наяд төгрөгт хүрч, 2010 онтой харьцуулахад 2.4 их наяд төгрөгөөр буюу 79.6%-иар мөн өссөн үзүүлэлттэй байна. Нийт активт цэвэр зээлийн эзлэх хувь 2010 оны эцэст 48% байсан бол 2011 оны эцэст 57.4%-ийг эзэлж байна. Чанаргүй зээл 326.8 тэрбум төгрөгт болж (2010 онд 370.5) өмнөх оноос 11.7%-иар буурсан. Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 2010 онд 11.5%-аас 5.8% болж буурч зээлийн чанар сайжирсан үзүүлэлттэй байна.

Банкны салбарын хэмжээнд 2011 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад харилцах, хугацаагүй хадгаламж болон хугацаатай хадгаламж тус бүр 30%, 37%, 41%-ийн өсөлттэй буюу 459 тэрбум, 337 тэрбум, 737 тэрбум төгрөгөөр тус тус өсч, 1,981 тэрбум, 1,238 тэрбум, 2,520 тэрбум төгрөгт хүрсэн байна. Банкны салбарын тухайн жилийн ашиг 2011 онд өмнөх оны мөн үеэс 118.5 тэрбум төгрөг буюу 180%-ийн өсөлттэй гарч 184.2 тэрбум төгрөгт хүрсэн бол өөрийн хөрөнгө 294.4 тэрбум төгрөг буюу 77%-иар өсөж 677 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Өмнөх жилүүдийн байдлаас харахад эдийн засаг өсөхийн хэрээр банкны салбар ч мөн өндөр өсөлтийг үзүүлж байна. Тиймээс 2012 онд улсын эдийн засгийн өсөлт, тэр дундаа уул уурхайн олборлолт, түүнээс олох орлогын өсөлт, төсвийн тэлэлт зэргээс шалтгаалан банкны салбар 30%-аас доошгүй хувиар өсөх хандлагатай байна. Мөн 2012 онд Монголын хөрөнгийн биржийн шинэчлэлт хийгдэж байгаатай холбоотойгоор арилжааны банкуудад өмнө эрхэлж байгаагүй клиринг болон кастадион банкны үйл ажиллагаа эрхлэх үүд хаалга нээгдээд байна. ХХБ нь 2012 оны 4 дүгээр сард Монголын анхны үнэт цаасны клирингийн үйлчилгээ үзүүлэгч банк болоод байна.



# ХХБ-НЫ 2012 ОНЫ ЗОРИЛТ

Худалдаа Хөгжлийн Банк нь 2012 онд харилцагчдын эрэлт, хэрэгцээнд маш мэдрэмжтэй, уян хатан ажиллаж, зах зээл дэх байр сууриа батжуулан бэхжүүлэх, зах зээлийн хувия нэмэгдүүлэх ба үүнд хүрэхийн тулд харилцагчийн үйлчилгээ, огтолцоо худалдаа болон ашигт ажиллагаанд түлхүү анхаарал хандуулна. Тавигдсан зорилгыг биелүүлэхэд хүний нөөцийн мэдлэг, ур чадвар, хандлага чухал байгаа тул "TDB" байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр боловсруулан сургалт, семинарыг зохион байгуулна.

Байгууллагын банкны зах зээл дэх одоогийн харилцагчдад хүргэж буй үйлчилгээгээ чанаржуулах, огтолцоо худалдааг нэмэгдүүлэхээс гадна аж үйлдвэрийн бусад салбарын харилцагчдыг уян хатан нөхцөлөөр татахад анхаарна. Гадаад худалдааны санхүүжилтийн бизнесийг өргөжүүлэхийн зэрэгцээ гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран синдикат зээл олгох болон бусад таатай нөхцлүүдийг харилцагчдадаа үргэлжлүүлэн хүргэнэ.

Иргэдийн банкны зах зээлд харилцагчдад хүрэх сувгийн тоог нэмэгдүүлэхээс гадна цахим бүтээгдэхүүний дэвшилтэт технологийг харилцагчдад цогцоор хүргэхэд шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж ажиллана.

Бизнес өргөжин тэлэхийн хэрээр дотоод хяналтын функц, эрсдлийн удирдлагыг улам сайжруулах шаардлагатай болж байгаа бөгөөд энэ талаар тодорхой ахьсан түвшний ажлууд хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.



## БАНКНЫ ТАНИЛЦУУЛГА, ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Худалдаа, хөгжлийн банк нь 1990 онд Монгол улсад хоёр шатлалт банкны тогтолцоо үүссэн түүхэн цаг үед анхны арилжааны банк болон мэндэлсэн түүхтэй. Монголын банк санхүүгийн салбарын зах зээлд ууган банк болж байгуулагдсан цагасаа эхлэн олон улсын стандартад нийцсэн 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрийн 45 салбар, тооцооны төв, кассаар дамжуулан, нийт харилцагч та бүхэндээ цаг алдалгүй хүргэж, дотоод болон гадаадын зах зээл дээр Монгол улсын тэргүүлэгч банк гэсэн байр сууриа хадгалаар байна.

Мөн Монгол улсын эдийн засгийн хурдацтай өсөлтөд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулж буй эдийн засгийн гол салбаруудад үйл ажиллагаагаа явуулдаг гадаад, дотоодын томоохон аж ахуйн нэгж, корпорациуд, гадаадын хөрөнгө оруулагчдын бизнесийн найдвартай санхүүгийн хамтрагч нь байсаар ирсэн бөгөөд тэдний хүсэн хүлээж буй санхүүгийн цогц үйлчилгээнүүдийг чанарын өндөр түвшинд үргэлжлүүлэн хүргэж байна.

Монгол улсын банк санхүүгийн зах зээлд тэргүүлэгч Худалдаа, хөгжлийн банк нь томоохон аж ахуйн нэгж, байгууллагууд, жижиг дунд бизнес эрхлэгчид болон мянга, мянган харилцагч иргэддээ зориулан бизнесийн үйл ажиллагаа, худалдаа үйлчилгээг дэмжих бүх төрлийн урт ба дунд хугацааны санхүүжилт, зөвхөн танд зориулсан хувийн банкны үйлчилгээ, мөнгөө ашигтай удирдах хөрөнгө зохицуулалтын үйлчилгээ, валютын арилжаа болон гадаад төлбөр тооцоо зэрэг олон улсын стандартад бүрэн нийцсэн, хамгийн сүүлийн үеийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан банкны цогц үйлчилгээг харилцагчиддаа хүргэж байна.


# БИЗНЕСИЙН ТАНИЛЦУУЛГА

Ийнхүү харилцагч та бүхэнтэй тогтоосон удаан хугацааны харилцаан дээр үндэслэн олон улсын нэр хүнд бүхий томоохон санхүүгийн байгууллагуудын хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, зээлийн шугамын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын банк санхүүгийн 100 гаруй нэр хүнд бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тус банк нь Азийн Хөгжлийн Банк болон Олон Улсын Санхүүгийн Корпорациас санхүүжилт авч байсан Монголын анхны банк бөгөөд 2006 онд арилжааны банкуудаас анх удаа өөрийн үйл ажиллагаандаа олон улсын үнэлгээний Moody's агентлагаар үнэлгээ хийлгэн, банкны үйл ажиллагаа тогтвортой, сайн хэмээн дүгнэлт авч байсан ба энэхүү үнэлэлтэндээ тулгуурлан Монгол улсаас олон улсын санхүүгийн зах зээлд 300 сая ам.долларын бондын хөтөлбөрийн хүрээнд 75 сая ам долларын бондыг 2007 онд амжилттай гаргаж чадсан анхны аж ахуйн нэгж болсон юм. Энэ хөтөлбөрт Moody's агентлаг гадаад валютаар гаргасан барьцаагүй үнэт цаасны Va2 үнэлгээг өгсөн билээ.


Дэлхийн эдийн засгийн хямралыг үл харгалzan өөрийн бондын өрийг хугацаанаас нь өмнө төлж барагдуулан улмаар 2010 оны 10-р сард 300 сая ам.долларын Европын дунд хугацааны үнэт цаасны хөтөлбөрийн хүрээнд олон улсын санхүүгийн зах зээл дээр нийт 175 сая ам.долларын бондыг амжилттай арилжаалсан ба дээрх бондын 25 сая ам.долларын бонд нь хоёрдогч өглөг хэлбэрээр, 5 жилийн хугацаатай гаргасан Монголын анхны хоёрдогч өглөгийн бонд байлаа. ХХБ-наас 2 дахь удаагаа гаргасан энэхүү бондыг нийт 69 хөрөнгө оруулагчдын 42 хувь нь дэлхийн нэр хүндтэй хөрөнгийн удирдлагын компаниуд, 25 хувь нь дэлхийн томоохон банкууд, 18 хувь нь хөрөнгө оруулалтын сангрууд байсан ба үлдсэн 11 хувийг нь бусад санхүүгийн байгууллагууд бүрдүүлсэн юм.

Өнөөдрийн байдлаар Худалдаа, хөгжлийн банк нь олон улсад нэр хүнд бүхий томоохон банк санхүүгийн байгууллага, банкуутдай хамтран төсөл, санхүүжилтийн хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд энэ нь Монгол улсын эдийн засгийн өсөлтөд томоохон түлхэц болохуйц үйл явдал юм. ХХБ-ны зах зээлд тэргүүлж буй амжилтуудыг үнэлэн "The Banker" сэтгүүл Монгол улсын шилдэг банк" шагналыг 2 удаа, Монгол улсын Засгийн газар болон бусад гадаад, дотоодын байгууллагууд "Монгол улсын тэргүүлэгч банк", "Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэгч байгууллага", "Шилдэг татвар төлөгч", "VISA International" байгууллагын 4 удаагийн нэрэмжит шагналууд болон 2011 онд Дэлхийн худалдааны тойм сэтгүүлээс "Монголын шилдэг худалдааны санхүүжилт үзүүлэгч банк" болон Монгол улсын Гадаадын хөрөнгө оруулалтын газраас "Хөрөнгө оруулалтын элч" зэрэг шагналуудаар тус тус урамшуулагджээ. 2011 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар ХХБ-ны нийт актив 2,090.0 тэрбум төгрөг болон өсч, нийт банкны зах зээлийн 22.3%, өөрийн хөрөнгийн хэмжээгээр 139.4 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт банкны зах зээлийн 27.3% тус тус эзэлж байна. Татварын дараах ашгийн хэмжээ 2009 онд 15.0 тэрбум, 2010 онд 20.7 тэрбум төгрөг байсан бол 2011 онд 42.1 тэрбум төгрөг болж өссөн байна.


Нийт өөрийн хөрөнгийн зах зээлд эзлэх хувь




Ашгийн эзлэх хувь




Зээлийн зах зээлд эзлэх хувь



Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зах



Нийт активын зах зээлд эзлэх хувь



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Худалдаа, хөгжлийн банк нь олон улсын туршлагаар шалгарсан компанийн засаглалын бүхий л хэм хэмжээг дэмжин ажилладаг бөгөөд дээд түвшний, тогтвортой, төгөлдөржсөн байгууллагын засаглал нь билний үйл ажиллагааны гол чиглүүлэгч болдог.

Бид компанийн засаглалын бүтэцдээ Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Удирдлагын багийн гишүүд, хувь нийлүүлэгчдийн хамтын ажиллагаа, нягт харилцааг нарийн тодорхойлж, байгууллагынхаа эрхэм зорилго, зорилтдоо хүрэхийн тулд хувь хүн бүр ёс зүйн ямар хэм хэмжээг үйл ажиллагаандaa баримтлахыг нарийвчлан заасан байдаг.

## Төлөөлөн удирдах зөвлөл

ХХБ-ны ТУЗ нь байгууллагын бүхий л шатанд ил тод, үнэнч шудрага байдлыг чухалчилан, нээлттэй засаглалыг бий болгохын зэрэгцээ ямар ч нөхцөлд тохирсон алсын хараа, стратеги бодлогоор банкны үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.

## Удирдлагын баг

ХХБ-ны Удирдлагын баг нь банк, санхүүгийн чадварлаг менежерүүдээс бүрддэг ба компанийн засаглалын зохицтой бүтэц, олон жилийн туршлага нь удирдлагын багийн амжилттай ажиллах суурь нь болдог төдийгүй банкны урт удаан хугацааны ашигт ажиллагааг хангах, улмаар хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг өсгөх боломжийг олгодог.

## Амжилтнууд


ХХБ-ны амжилтын үндэс нь эрч хүчтэй, чадварлаг амжилтнууд бөгөөд тэднийг шудрагаар урамшуулж, албан тушаал дэвшүүлэх хөгжлийн тогтолцоог сайжруулснаар харилцагчиддаа банкны шилдэг үйлчилгээг үзүүлж чаддаг.

## Бид

ХХБ нь хууль, ёс зүйн хариуцлагын хүрээнд нийцсэн ажиллах орчинг бүрдүүлэхийг үргэлж эрмэлзсээр ирсэн бөгөөд харилцагч, бизнесийн түншүүд болон нийгэмдээ банкны шилдэг үйлчилгээг үзүүлэн, хувь нийлүүлэгчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ аливаа амжилт нь шудрага байх ёстой гэдэгт итгэдэг.



## ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУТЭЦ



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ



## ТУЗ, ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

#### ТУЗ-ЫН ДАРГА

Должин ЭРДЭНЭБИЛЭГ

#### Гишүүд

Рандолф Коппа  
Долгоржав БАТЖАРГАЛ  
Чулуунбаатар ЭНХБОЛД  
Тамир ЦОЛМОН

#### Ерөнхий аудитор

Дамдин ГАНТӨГС

#### Банкны нарийн бичгийн дарга

Дашэвэг Даваажав

### УДИРДЛАГЫН БАГ

#### Ерөнхийлөгч

Рандолф КОППА

#### Гүйцэтгэх захирал

Балбар МЭДРЭЭ

#### Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч

Онон ОРХОН

#### Гүйцэтгэх захирлын орлогч

Санжаасүрэн ОРГОДОЛ

#### Гүйцэтгэх захирлын орлогч

Дэмчигжав ОТГОНБИЛЭГ

#### Гүйцэтгэх захирлын орлогч

Лхагвасүрэн СОРОНЗОНБОЛД

#### Гүйцэтгэх захирлын орлогч

Дамбийжав ХҮРЭЛБААТАР



**Ноён О.ОРХОН**

Гүйцэтгэх захирлын  
тэргүүн орлогч



**Ноён Л.СОРОНЗОНБОЛД**

Гүйцэтгэх захирлын орлогч



**Ноён Д.ХҮРЭЛБААТАР**

Гүйцэтгэх захирлын орлогч



**Хатагтай Д.ОТГОНБИЛЭГ**

Гүйцэтгэх захирлын орлогч



**Ноён С.ОРГОДОЛ**

Гүйцэтгэх захирлын орлогч

# УДИРДЛАГЫН БАГ



01

**Н.НЯМСҮРЭН**

02

**Л.НЯМСҮРЭН**

03

**Д.ДИНЖМАА**

Байгууллагын банкны газрын захирал

Захиргаа, хүний нөөцийн газрын захирал

Санхүү удирдлага, хяналтын газрын захирал

04

**Б.БАЯРМАА**

05

**П.УЛАМ-ЭНХТУЯА**

06

**И.ОРХОНХҮҮ**

07

**П.ГАНТУУЛ**

Иргэдийн банкны газрын захирал

Салбарын удирдлагын газрын захирал

Мэдээллийн технологийн газрын захирал

Дотоод аудитын газрын захирал



08      **Х.ГАНЦЭЦЭГ**  
09      **А.МОНХБАЯСГАЛАН**  
10      **Ш.ЭРДЭНЭБААТАР**  
11      **Ц.ГАНБАЯР**

Картын удирдлагын газрын захирал  
Маркетингийн газрын захирал  
Хамгаалалт, аюулгүй байдлын газрын захирал  
Хуулийн газрын захирал

12      **А.БАТЗОРИГ**  
13      **Б.ЭРХЭМБАЯР**  
14      **Л.ГАНТӨМӨР**

Эрсдлийн удирдлагын газрын захирал  
Олон улсын банкны газрын захирал  
Хөрөнгө зохицуулалтын газрын захирал

# 2011 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД


- > 2011 онд ХХБ санхүүгийн голлох үзүүлэлтүүдээ сайн түвшинд хүргэж ажиллалаа. Тайлант онд нийт активын хэмжээ 2,090.0 тэрбум төгрөг, татварын дараах цэвэр ашиг 42.1 тэрбум төгрөг болж өнгөрөгч оноос 21.4 тэрбум төгрөг буюу 103.4 хувиар өссөн байна.
- > Төрийн болон дотоодын компаниудад санхүүжилт босгох, гадаад, дотоодын хөрөнгийн бирж дээр компаниудын бонд болон хувьцаагаа гаргах, уул уурхай, хайгуулын ажлыг санхүүжүүлэх, харилцагчдад санхүүгийн болон хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх, андеррайтер, брокерийн үйл ажиллагааг явуулах зэрэг хөрөнгө оруулалтын банкны олон төрлийн цогц үйлчилгээг үзүүлэх TDB Capital компанийг байгууллаа.
- > "The Mongolian Mining Journal" сэтгүүлээс зохион байгуулсан "Mining Journal Awards 2011" шалгаруулалтаас "Уул уурхайг дэмжигч байгууллага" –аар шалгарлаа.
- > Дэлхийн бизнес, санхүүгийн мэдээ, мэдээллийн тэргүүлэгч Bloomberg Media Group –тэй хамтран Блумбергийн шинэ суваг болох "Bloomberg TV Mongolia"-г бий болголоо.
- > Улаанбаатар хотод бизнес үйлчилгээ, хүн ам төвлөрсөн бүсүүдэд нийт 10 салбар, орон нутагт "Дархан", "Эрдэнэт", "Өмнөговь", "Хөтөл"-д тус тус нэг салбар нээлээ.
- > Тайлант онд 2010 онтой харьцуулахад шинээр томилогдон ажиллаж буй ажилчдын тоо 68.6 хувиар буюу 380 –аар өсж, нийт ажилчдын тоо 1,014 боллоо.
- > ХХБ-ны бүтээгдэхүүн, үйлчилгээний тухай мэдээллийг цогцоор нь хүргэх боломжтой 24 цагийн үйлчилгээтэй мэдээллийн лавлах утас 1977 тусгай дугаарыг бий болгож, үйл ажиллагааг оны сүүлээр эхлүүллээ.
- > БНХАУ-ын "Тариалангийн банк", "Үйлдвэрлэл худалдааны банк" болон Бугат хотын "Бао Шан" зэрэг банкуудтай импортын санхүүжилтийн гэрээг байгууллаа.
- > Солонгосын экспорт, импортын банкны Импортын санхүүжилтийн зээлийн шугамын хэмжээ 20 сая ам.доллар болон нэмэгдлээ.
- > Хөрөнгийн биржийн хөгжил, шинэчлэлтэд зориулан ХХБ болон Монголын арилжааны банкууд хамтран, 14 сая 200 мянган ам.долларын санхүүжилтийн зээл олгох гэрээг үзэглэлээ.
- > "Картаар үйлчилгэч байгууллагуудын зөвлөгөөн" 4 дэх жилдээ амжилттай зохион байгуулагдаж, ХХБ-ны картаар үйлчилгээ үзүүлдэг байгууллагын төлөөлөл болж, нийт 150 гаруй бие төлөөлөгчид оролцлоо.
- > Дэлхийн худалдааны тойм сэтгүүлээс "Азийн худалдааны тэргүүлэгчид 2011" шалгаруулалт явагдаж 2011 оны Монгол улсын шилдэг гадаад худалдааны санхүүжилт үзүүлэгч банкаар шалгарлаа.
- > Дэлхийн 12 улсын банкны салбарт 40 гаруй жил ажилласан арвин туршлагаа Монгол улсын банк санхүүгийн салбарт зориулж буй шинэлэг үзэл, оновчтой санаагаараа онцгойрон ялгардаг ХХБ-ны Ерөнхийлөгч Р.Коппа төрийн өндөр дээд шагнал Алтан гадас одон хүртлээ.



## АМЖИЛТЫН ТОВЧООН

- > MYXAYT, Засгийн газар хамтран шалгаруулдаг Монгол улсын ТОП-5 банкны шилдэг банкаар шалгарлаа. Энэхүү шагналыг банкны салбарт авч хэрэгжүүлсэн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээ, шилдэг үйл ажиллагаагаараа хүртсэн бөгөөд тус шалгаруулалтад “Компанийн нийгмийн хариуцлага”-ын үзүүлэлтээрээ тэргүүлсэн байна.
- > Нийт шагнал урамшуулалт авсан ажилтнуудын 13.6 хувь нь төрийн одон, медаль, 22.9 хувь нь Монголбанкны шагналаар (СБТА, МБ-ны хүндэт жуух, баярын бичиг), 21.2 хувь нь оны тэргүүний ажилтнаар, 8.5 хувь нь бусад яам, тамгын газар, МЗХ-ны шагналаар шагнагдсан ба ХХБ-ны нийт ажилтнуудын 9 ажилтан тутмын нэг нь шагнагдсан байна.
- > Жил бүр хамт олныхоо итгэлийг хүлээсэн мэргэжил, ур чадвараараа амжилт гаргасан ажилтнуудыг гадаад орон руу аялуулдаг бөгөөд 2011 онд Хонконг, Макоа улсад 40 ажилтан аяллаа.
- > 2011 оны 10-р сарын 10-ны өдөр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын хөрөнгө оруулалтын газрын 15 жилийн ойн арга хэмжээ ёслол төгөлдөр болж өнгөрсөн бөгөөд ойн баярын хүрээнд хамтран ажиллагч, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжигч шилдэг байгууллагуудаа шалгарууллаа. Уг үйл ажиллагаанд “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭЛЧ” хэмээх нэр хүнд бүхий шагналыг Худалдаа, хөгжлийн банк бусад байгууллагуудаас тэргүүлэн гардан авлаа.
- > Дэлхийн худалдааны тойм сэтгүүлээс “Азийн худалдааны тэргүүлэгчид 2011” шалгаруулалт явагдаж 2011 оны Монгол улсын шилдэг гадаад худалдааны санхүүжилт үзүүлэгч банкаар тодрууллаа.
- > Дэлхийн 12 улсын банкны салбарт 40 гаруй жил ажилласан арвин туршлагаа Монгол улсын банк санхүүгийн салбарт зориулж, шинэлэг үзэл, оновчтой санаагаараа онцгойрон ялгардаг ХХБ-ны Ерөнхийлөгч Р.Коппа төрийн өндөр дээд шагнал Алтан гадас одон хүртлээ.
- > “The Mongolian Mining Journal” сэтгүүлээс зохион байгуулсан “Mining Journal Awards 2011” шалгаруулалтаас “Уул уурхайг дэмжигч байгууллага” –аар шалгарлаа.





БИЗНЕСИЙН  
ҮЙЛ  
АЖИЛЛАГАА





TDB, the largest corporate lender in Mongolia, maintained its leading position in trade related transactions based on its clientele base comprised of the country's major corporations across all business sectors. In 2011, TDB alone handled almost 50% of Mongolia's trade finance related transactions. Currently, the bank has established direct correspondent relationships with over 150 international financial institutions.

Established in 1990 as the first commercial bank of the country, TDB prides itself for its leading position as the universal banking service provider, offering a full range of services delivered with dynamism and excellence in service and quality. TDB was the first to introduce modern banking technology, adopt IASB standards in financial reporting, become a member of SWIFT network, offer card and ATM services and commence gold exports into the foreign market. As the top international expertise derived from State Bank of Mongolia origins, TDB is undoubtedly the international face of Mongolia with strong capabilities in corporate banking, international banking, treasury, retail and SME banking.

- Mongolia's NUMBER ONE corporate bank
- In 2011, TDB has become the first Mongolian bank to obtain the investment banking license to further diversify its business.
- The country's first bond issuer on the international debt market
- Superior profitability and efficiency
- The largest market share by its assets and profits as of 2Q, 2012
- The leading international trade facilitator of Mongolia to win "Best trade finance bank in Mongolia 2011" and "Best trade finance bank in Mongolia 2012" awards by "Global Trade Review" Magazine.



БАЙГУУЛЛАГЫН  
БАНКНЫ УЙЛ  
АЖИЛЛАГАА

> ЖИЖИГ ДУНД  
БАЙГУУЛЛАГЫН  
ЗЭЭЛИЙН УЙЛ  
АЖИЛЛАГАА



# БАЙГУУЛЛАГЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## БАЙГУУЛЛАГЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бидэнтэй тууштай хамтран ажиллаж буй жижиг дунд бизнес эрхлэгчид, зах зээлд өөрийн байр сууриа эзэлсэн том аж ахуйн нэгж, байгууллагууд болон шинээр хамтран ажилласан байгууллага, түншүүдийн бизнесийн хэрэгцээ, үйл ажиллагааны өсөлттэй уялдуулан тэдгээрийн санхүүгийн хэрэгцээнд нийцсэн зээлийн болон бусад бүтээгдэхүүн, үйлчилгээг уян хатан нөхцөлөөр үзүүлж ажиллаж байна.

Байгууллагад сууринсан бүтээгдэхүүн үйлчилгээг боловсронгуй болгох, харилцагчидад үйлчилгээний таатай орчинг салбар, тооцооны төвүүд болон бизнесийн газар, нэгжүүдээр дамжуулан хүргэхээр зорьж ажилласны үр дүнд байгууллагын харилцах дансаар татан төвлөрүүлсэн хөрөнгө, байгууллагад олгосон нийт зээлийн багц, харилцагч байгууллагын тоо 2010 оны өсөлтөө бататган илүү амжилттай ажилласан жил байлаа.

2011 онд харилцагч аж ахуй нэгж, байгууллагуудын бизнесийн хэрэгцээнд тулгуурлан харилцагчдын санхүүгийн хэрэгцээг бүрэн хангасан, тэдний бизнесийн онцлогт тохирсон зээлийн бүтээгдэхүүнийг уян хатан нөхцөлтэй олгож, нийт том харилцагчийн зээлийн багц 110.4%-иар өслөө.

Цаашид банк эдийн засгийн бүхий л салбарт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, түүн дотроос уул уурхайн голлох харилцагчид болон тэдгээртэй хамтран ажилладаг гүйцэтгэгч компаниудад зориулсан санхүүгийн үйлчилгээг бага зардлаар, хугацааны таатай нөхцөлөөр дотоод болон гадаад эх үүсвэр, худалдааны санхүүжилтээр дамжуулан олгоход чиглэн ажиллана.

126% Байгууллагад олгосон нийт зээлийн багцын өсөлт

19% Байгууллагын харилцах дансаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлт

15% Нийт харилцагч байгууллагын тооны өсөлт



# ЖИЖИГ ДУНД БАЙГУУЛЛАГЫН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаагаа өргөтгөх, цар хүрээгээ тэлэхэд нь банкны зүгээс харилцагчийн бизнесийн онцлогт тохирсон зээлийн бүтээгдэхүүнийг санал болгохын зэрэгцээ бага хүүтэй, урт хугацаатай төслийн зээлүүдийг тулхуу борлуулж гадны олон төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн.

2011 онд банк жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл-II, Дэлхийн банкны Хувийн хэвшилийг хөгжүүлэх төсөл-II, Германы KfW болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэртэй дунд хугацааны хөрөнгө оруулалтын зээлийн хөтөлбөрүүдийг амжилттай үргэлжлүүлэн нийт жижиг, дунд зээлийн багцыг 62.5 тэрбум төгрөгт хүргэсэн.

Жижиг, дунд зээлийн багц (тэрбум төгрөгөөр)					
2007.12.31	2008.12.31	2009.12.31	2010.12.31	2011.12.31	Increase (2011/2010)
16.3	20.3	17.2	20.2	62.5	209.4%


Төслийн зээлийн багц (тэрбум төгрөгөөр)			
2009.12.31	2010.12.31	2011.12.31	Increase (2011/2010)
8.1	6.7	44.0	560.4%

Банкны жижиг, дунд зээлийн багц 2011 онд 209.4 хувиар өссөн нь сүүлийн 5 жилийн хугацаанд гарсан онцгой өсөлт байлаа. Зээлдэгч аж ахуйн нэгж, байгууллагад уян хатан нөхцөлөөр зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож ажилласнаар жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бизнесийн цар хүрээгээ тэлэх, үйл ажиллагаагаа өргөтгөхөд нь томоохон тулхэц болсон. 2011 онд өмнөх жилтэй харьцуулахад олгосон төслийн зээлийн хэмжээ 560.4%-иар өссөн. Засгийн газраас Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, ноос, ноолууран эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хөнгөлттэй зээл олгох зорилгоор 300.0 тэрбум төгрөгийн бонд гаргаж, бондын эх үүсвэрээр дээрх үйлдвэрүүдэд арилжааны банкуудаар дамжуулан зээл олгосон. Энэхүү хөтөлбөрт манай банк зуучлагч санхүүгийн байгууллагаар амжилттай шалгарч, гэрээ байгуулан 11 харилцагчийн дэд төслийг амжилттай санхүүжүүллээ.

## Төслийн зээлийн багцын бүтэц

Тайлант хугацааны ажлын үр дүн болон зээлдэгчдийн бизнесийн өсөлтийг цаашид хадгалж, 2012 онд жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд зээлийн бүтээгдэхүүнийг үргэлжлүүлэн хүргэхийн зэрэгцээ төслийн зээл, худалдааны санхүүжилтийн багц үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд, эрсдэлгүй, хямд зардлаар, уян хатан нөхцөлтэй хүргэх зорилтой ажиллаж байна.

"АХБ-ны нэмүү өргтгийн сүлжээг хөгжүүлэх" хөтөлбөрийг эхлүүлсэн нь жижиг, дунд харилцагчдад бага зардлаар санхүүжилт авах нөхцөлийг шинээр бий болгосон.



## ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТ

Худалдааны санхүүжилтийн хэрэгслүүдийг ашиглан гадаад худалдааны төлбөр тооцоонд гарч болох эрсдэлийг бууруулах, санхүүгийн эх үүсвэрийг таатай нөхцөлөөр харилцагчдад хүргэхээр ажилласан. Монгол улсын гадаад худалдааны эрчимтэй өсөлт нь банкны гадаад төлбөр тооцоо, худалдааны санхүүжилтийн хэрэгслүүдийн ашиглалтыг нэмэгдүүлсэн төдийгүй гадаад худалдаанд оролцогч талуудын хэрэглэх сонирхол өмнөх жилийдтэй харьцуулахад нилээд өссөн. Тайлант оны эцэсээр импортын аккредитив, баталгааны хэмжээг 2010 оны эцэстэй харьцуулахад 86%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Гадаад худалдааны санхүүжилтийн багц үйлчилгээгээр импорт, экспортын аккредитив, банкны баталгааг гадаад руу гаргах, гадаадаас хулээн авч харилцагчидад мэдэгдэхийн зэрэгцээ дахин санхүүжилтийн хөтөлбөрүүдийг ING bank, Commerzbank, Export Import Bank of Korea, ICBC bank, Russian Agricultural bank зэрэг дэлхийн тэргүүлэгч 30 гаруй банкуудтай хамтран амжилттай хэрэгжүүлсээр байна.

Монгол улсын эдийн засгийн өсөлтөд гол нөлөө үзүүлж буй уул уурхайн салбарын хөгжлийг дагаад гадаад худалдааны төлбөр тооцооны хэрэгслүүдийг харилцагчид өргөн хэрэглэх хандлагатай болж байна. Цаашид гадаад худалдааны санхүүжилтийн хэрэгслүүдийн шинэ боломжийг дэлхийн нэр хүнд бүхий корреспондент банкуудтай хамтран хэрэгжүүлэхэд анхаарал хандуулан ажиллах төдийгүй үйлчилгээний чанарыг сайжруулж, мэргэжилтнүүдийнхээ ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.


“Дэлхийн худалдааны тойм” сэтгүүлээс Азийн нийт 26 орны шилдэг худалдааны санхүүжилтийг үзүүлэгч банкны шалгаруулалтыг явуулсан бөгөөд Монгол улсаас Худалдаа, хөгжлийн банкыг тодруулан өргөмжиллөө.

## БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАХ ДАНС


Байгууллагын харилцах дансаар татан төвлөрүүлсэн хөрөнгө нэмэгдсэн нь уул уурхай болон барилгын салбарын мөнгөний урсгал, хөрөнгө оруулалт үлэмж хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой байна. Улмаар 2010 онд 44%-ийн өсөлтийг үзүүлж байсан бол 2011 онд 47%-ийн өсөлтөөр өмнөх оны үзүүлэлтээ бататгасан байна.

Байгууллагын харилцах дансанд суурилсан цүнхээр мөнгө хураах, дотоод, гадаадад баталгаа гаргах, төлбөрийн нэхэмжлэхээр үйлчилгээ үзүүлэх, гадаад гүйвуулга хийх, байгууллагын цалин олгох, валютын арилжаа зэрэг бүх төрлийн үйлчилгээг харилцагчдадаа үзүүлж байгаагийн сацуу эдгээр үйлчилгээний шимтгэлийн орлого нь өмнөх онтой харьцуулахад 50 хүртэл хувийн өсөлтийг үзүүлсэн байна.


Импортын аккредитив болон баталгааны дүн



Гадаад руу нээгдсэн аккредитив, баталгааны бүтэц



Байгууллагын харилцахын үлдэгдэл





ИРГЭДИЙН  
БАНКНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГАА

> ИРГЭДИЙН  
ХАРИЛЦАХ,  
ХАДГАЛАМЖ

# ИРГЭДИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2011 онд ХХБ нь зээлийн уян хатан бөгөөд тэлэлтийн бодлогыг баримтлан ажиллаж, харилцагчиддаа хүү, шимтгэлийн хамгийн таатай, зах зээлд өрсөлдөхүйц нөхцлөөр иргэдийн хувийн хэрэгцээ болон жижиг, жижиг дунд бизнесийн хэрэгцээг хангах бүх төрлийн зээлийн үйлчилгээг үзүүлснээр өмнөх оноос зээлийн багцын хэмжээг даруй 3.8 дахин өсгөж, банкны салбарт иргэдийн зээлийн багцын есөлтөөрөө тэргүүн энгээнд бичигдлээ.

Салбар, тооцооны төвүүдийн тоо болон хүчин чадлыг нэмэгдүүлж, харилцагчид хурдан, шуурхай үйлчлэх зорилгоор зээлийн хүсэлт шийдвэрлэх, олгох үйл ажиллагааны гар ажиллагааг багасгаж, хялбаршуулсан нь энэхүү амжилтад мөн нөлөөллөө. Иргэдийн санхүүгийн бүх төрлийн хэрэгцээг хангах зорилгоор автомашины зээлийн нэр төрлийг нэмэгдүүлэн хуучин автомашины зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүллээ.

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн урт хугацаатай, бага хүйтэй зээлийг санал болгон ажилалаа.

### Орон сууцны зээл

ХХБанк нь орон сууцжуулах үйл ажиллагааг идэвхитэй дэмжиж ажилладаг банкны хувьд орон сууцны зээлийн багцыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 290.4%-иар өсгөсөн. Энэ үзүүлэлт нь нийт банкны системийн 22.3%-д хүрсэн баадам амжилтыг үзүүлсэн. Үүнд орон сууцны эрэлт хэрэгцээ, банкны бодлого, Засгийн газраас хэрэгжүүлж буй орон сууцны хөтөлбөрүүдээс иргэдийн зээлийн талаарх мэдээлэл нэмэгдсэн зэрэг хүчин зүйлс ихээр нөлөөлсөн байна.

Банк нь өөрийн харилцагч байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулж хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцны зээлийг урт хугацаагаар олгох боломжийг бий болгон харилцагчидтайгаа нягт уялдаатай хамтран ажиллаж ирлээ.


Түүнчлэн тодорхой барилгын компаниудтай тусгай нөхцлөөр хамтран ажиллаж, зээлдэгчдэд чанартай барилгаас худалдан авах, таатай нөхцлөөр зээлд хамрагдах боломжийг үргэлжлүүлэн иргэдээ түгээж байгаа нь харилцагчдын таашаалыг хүртсэн юм.

Мөн 2011 онд бүтээн байгуулалтын салбарын оны шилдгүүдийг шалгаруулдаг “Алтан цамхаг-2011” ёслолын арга хэмжээнээс бүтээн байгуулалтыг дэмжигч банкаар шалгарсан нь нийгмийг хамарсан үйл ажиллагаанд ХХБ-ны оролцоо өндөр байгааг харуулж байна.


### Зээлийн үйл ажиллагаатай холбоотой онцлох тоон үзүүлэлтүүд

- > Нийт зээлдэгчийн тоо өмнөх оноос 64 хувиар өсч оны эцэст 27 мянгад хүрсэн;
- > Орон сууцны зээлийн жигнэсэн дундаж хүү тогтмол буурч төгрөгийн хүү 14.1% болсон нь ХХБ-наас хамгийн бага хүйтэй зээлийн санхүүжилтийг олгож байгаагийн илрэл юм;
- > Зээлийн багцын бүтэц тэнцвэржиж, бүх төрлийн зээлийн бүтээгдэхүүний борлуулалт жигд байна;

Иргэдийн зээлийн багцын  
өсөлт



Зээлийн багцын бүтэц



# ИРГЭДИЙН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ


2011 онд татан төвлөрүүлсэн хөрөнгө нэмэгдэхэд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, эдийн засгийн өсөлтөөс хамааран банкны системийн хадгаламжийн хэмжээ өссөн, харилцагч иргэдийн зүгээс банкинд итгэх итгэл нэмэгдсэн нь эерэгээр нөлөөлсөн байна.

ХХБ нь иргэдийн зах зээлд эзлэх байр суурь, салбарын тоо, нэр хүндээ өсгөснөөр харилцах, хадгаламжийн багцыг тогтвортойгоор нэмэгдүүлж, 2010 оны эцэстэй харьцуулахад 60.5%-иар өсгөж, банкны системд эзлэх хувия 19.5%-д хүргэсэн байна.

## Хадгаламжтай холбоотой онцлох тоон үзүүлэлтүүд

- > 2011 оны эцсээр нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 80 мянгад хүрсэн нь өмнөх оноос 32 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- > Нэг дансанд төвлөрсөн хадгаламжийн дундаж дүн 18 хувиар өссөн.

Иргэдийн харилцах, хадгаламж




## Ажил олгогчийн урамшуулалт хадгаламж

Ажил олгогчийн урамшуулалт хадгаламжийн үйлчилгээгээр хамтран ажиллах гэрээний дагуу урт хугацааны түншлэлт байгууллагуудтай хамтран ажиллаж эхэлсэн. Энэхүү хадгаламжийн үйлчилгээг байгууллагууд ажилтан, албан хаагчдаа урт хугацаанд тогтвортой ажиллуулах, урамшуулах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор өргөн хүрээнд ашиглах боломжтойгоороо онцлог юм.

## Хадгаламжийн сертификат

2008 онд анхлан зах зээлд нэвтрүүлсэн хадгаламжийн сертификатын үйлчилгээний ач холбогдол, үнэ цэнэ улам нэмэгдэж байгаагийн сацуу хөрөнгө оруулалтын чиглэлээр ашиглах, бэлэглэх, гэрээслэх, өвлүүлэх боломжтой байдгаараа хадгаламжийн бүтээгдэхүүнүүд дотроо чухал байр суурь эзэлж байна.

- > Иргэдийн харилцах, хадгаламжийн дансанд суурилсан үйлчилгээнүүдийн нэр төрлийг нэмэгдүүлэх, харилцагчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, банкны үйлчилгээг илүү хялбар, хүртээмжтэй байлгах үүднээс дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:
- > 2011 онд тогтмол шилжүүлэг буюу цалингийн данснаас хадгаламжийн данс руу тогтмол давтамжтайгаар, харилцагчийн захиалсан тогтмол дүнгээр гүйлгээ хийж хуримтлалаа нэмэгдүүлэх үйлчилгээний ач холбогдлыг харилцагчдад түлхүү ойлгуулах тал дээр анхаарал хандуулж ажиллалаа.
- > Хилийн чанадад оршин сууж байгаа Монгол Улсын иргэддээ тус банкинд данс нээж, мөнгөн хөрөнгөө найдвартай, эрсдэлгүйгээр хадгалуулах боломжийг нээх үүднээс “Интернэтээр хүсэлт хүлээн авч данс нээлгэх” үйлчилгээний эхний шатыг амжилттайгаар хэрэгжүүлж эхэллээ.
- > Харилцагчийн “банкны үйлчилгээг авах хугацаа”-г богиносгох, гэрээний эрсдэлийг бууруулах зорилгоор гар ажиллагааг багасгах, хялбаршуулах ажлуудыг хийсэн.



## **БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ**

### **Олон улсын шуурхай мөнгөн гүйвуулгын MoneyGram үйлчилгээ**

2011 онд шуурхай гүйвуулгын хувьд эргэлт хийсэн он байсан бөгөөд харилцагчдын эрэлт хэрэгцээ, санхүүгийн бодит боломж дээр үндэслэн MoneyGram үйлчилгээний Монгол Улсаас бусад улс орон руу шилжүүлэг хийх үнэ тарифыг эрс бууруулж, шинэчлэн тогтоосон. Гүйлгээний тооны өсөлт нь энэхүү өөрчлөлтийг харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн алхам болсоныг илтгэж байна.

Түүнчлэн программын автоматжуулалтын ажлыг өөрийн банк болон агент банкуудад амжилттай хэрэгжүүлж дуусгасан, мөн гүйлгээний баримтыг автоматжуулсан явдал нь зөвхөн Монгол Улсад төдийгүй Азии, Номхон далайн бүсэд анхдагч банк болсон бөгөөд харилцагчдад энэхүү үйлчилгээгээр үйлчлүүлэхэд хялбар болж, үйлчилгээг шинэ шатанд гаргалаа.

Агентбанкны гэрээг Капитал банктай үзэглэсэн явдал нь үйлчилгээний цэгүүдийн тоог нэмэгдүүлэх(ялангуяа хөдөө, орон нутагт), цар хүрээг өргөжүүлэх, үйлчилгээг харилцагчдад улам бүр ойртуулахад чухал ач холбогдолтой ажил боллоо.

Ирж буй 2012 онд бид MoneyGram үйлчилгээг илүү өндөр түвшинд гаргаж, гүйвуулгыг дансанд хүлээн авах, өөрийн хүссэн олон төрлийн валютаар гүйвуулга хүлээн авч, ханшийн эрсдэл хүлээхгүй байх зэрэг харилцагчынхаа эрх ашигт нийцсэн шийдлүүдийг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

### **Мөнгөн гүйвуулгын PayEasy үйлчилгээ**

БНСУ-ын Napa банк, PayOne компанийт хамтран хэрэгжүүлдэг PayEasy үйлчилгээг тус улсад албан ёсоор ажиллаж, амьдарч буй 10 хүн тутмын 1 нь ашиглаж буй нь эдгээр иргэд өөрсдийн санхүүгийн хэрэгцээг өөрийн улсын банкаар дамжуулан авах, эх орондоо хөрөнгө оруулалт хийх, өөрсдийн мөнгөн хөрөнгийг арвижуулах, хамгийн хямд шимтгэлээр эх орон руугаа мөнгө гүйвуулах зэрэгт түйлын ач холбогдолтой үйлчилгээ юм.

### **ХУВИЙН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ**

Банкны салбар, тооцооны төвүүдийн тоог нэмэгдүүлэн, өдрөөс өдөрт өргөжиж буй тус банк нь анх 2004 онд байгуулгасан Хувийн банк төвийг 2011 оны 5 дугаар сараас "Хувийн банк" тооцооны төв болон өргөжүүлж, VIP харилцагчдад зориулсан бүх төрлийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд, шуурхай үзүүлэх эрхэм зорилгоо улам бататгалаа.

Үүний зэрэгцээ 2011 оны 8 болон 10 дугаар саруудад үйл ажиллагаагаа эхэлж, гол голомтоо бадраасан "Зайсан" тооцооны төв, "Централ тауэр" салбар нь хувийн банкны үйлчилгээний орчин, үйлчилгээний жишиг тогтоосон, харилцагч үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээ, тав тухыг хангасан, нэг дороос банкны бүх төрлийн үйлчилгээг авч болохуйц салбарууд болсноороо харилцагчдын талархал, сайшаалыг хүртээд байна.

A professional woman with long dark hair, wearing a bright blue blazer over a black top, is smiling at the camera. She is holding a colorful credit card in her right hand, which is resting on a white surface. The background is blurred, suggesting an office or retail environment.

КARTЫН  
БИЗНЕСИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА

# КАРТЫН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## ЦАХИМ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Тасралтгүй хувьсан өөрчлөгдхөх технологийн хөгжил, техникийн дэвшил болон даяарчлалын нөлөөллөөс хамааран хүний хэрэгцээ, шаардлага хувьсан өөрчлөгдөх байгаатай холбогдон банкны бизнес урьд өмнө таамаглаж байгаагүйгээр хөгжиж байна. Энэ бол банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг цаг хугацаа, орон зайд, аливаа нөлөөллөөс үл хамааран үзүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага юм. Монгол улсад интернэт хэрэглэгчийн тоо даруй нэг сая гаруй, бүртгэлтэй интернэт хэрэглэгчдийн тоо 400 мянгад хүрсэн бол гар утас хэрэглэгчдийн тоо давхардсан тоогоороо даруй 2.8 саяд хүрсэн нь өргөн уудам нутаг, уул уурхай дагасан бизнес болон амьдралын хэв маяг, нөгөө талаас дэд бүтцийн хөгжил муу, биет банкны салбар байгуулахад өндөр өртөгтэй байх, нэгж харилцагчийн өгөөж багатай зэрэг шалтгаанууд нь цахим банкны бизнесийг хөгжүүлэх зайлшгүй нөхцлийг үүсгэж байна. Худалдаа, хөгжлийн банкны цахим банкны үйлчилгээний бодлого нь өөрийн байгууллагын харилцагчид болон тэдгээрийн ажилтан албан хаагч, гэр бүлийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэхийн сацуу тэдний ирээдүйн цахим банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг хангах илүү өргөн чиглэлийг баримтлан ажиллана.

Тус банк нь 2011 онд карт, интернэт банк зэрэг цахим бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагч олондоо илүү боловсронгуй болгон хүргэн ажилласны зэрэгцээ цахим банкны дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрсөн хамгийн үр ашигтай, харилцагчдын үндсэн эх үүсвэр болох үүрэн телефонд суурилсан утсаараа банкны үйлчилгээг авах үйлчилгээг нэвтрүүлэхээр техник хангамжийн бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.

## Төлбөрийн картын үйл ажиллагаа

ХХБ нь 2001 оноос Виза Уорлдвайд байгууллагын үндсэн гишүүн болсоноор өөрийн нэрийн төлбөрийн картыг зах зээлд анх гаргаж Монгол улсыг дэлхийн хэмжээний төлбөрийн сүлжээнд нэгтгэн оруулсан билээ. 2010 онд бид Энгийн, Алтан, Бизнес болон Платинум гэх үндсэн 4 төрлийн 24 зүйлийн соронзон болон EMV технологийн чиптэй дебит болон кредит картыг харилцагчдынхаа дотоод болон олон улсын хэрэгцээнд зориулан зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд харилцагч байгууллагынхаа эрэлт хэрэгцээнд нийцүүлсэн, тэдгээрийн харилцагчдад чиглэсэн хамтарсан /cobranded card/ төлбөрийн картуудыг зах зээлд гаргасан нь харилцагч байгууллага болоод үйлчлүүлэгчидийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн болж чадсан юм.

МТ Шатахууны Карт: Тайлант оны II улиралд автомашин эзэмшигч иргэд, байгууллагуудад зориулан “Магнай трейд” ХХК-тай хамтран шатахууны хөнгөлөлтийн “МТ” шатахууны картыг зах зээлд нэвтрүүлсэн нь карт эзэмшигчиддээ шатахуун худалдан авалт бүрт нь гүйлгээний үнийн дүнгийн 3%-ийн хөнгөлөлт эдлэх, шатахууны нийтийн хомдол үсэх тохиолдолд давуу эрхтэйгээр үйлчлүүлэхээс гадна картынхаа дансны орлого, зарлага, зарцуулалтыг бүрэн хянах боломжийг олгов.




2011 онд ХХБ өөрийн картын нэр төрлийг нэмэгдүүлэх, харилцагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх, хамтран ажиллагч байгууллагуудаа дэмжих зорилгоор хамтарсан картуудыг зах зээлд нэвтрүүллээ. Түүний нэг болох Орифлэйм карт нь Орифлэйм ХХК-ны зөвлөхүүд цалин, урамшууллаа уг картаараа дамжуулан авах, мөн Орифлэймийн бараа бүтээгдэхүүний захиалгын төлбөрийг интернэт болон ATM ашиглан төлөхөд зориулагдсан байх ба тухайн байгууллагын нэр, лого, дизайнтай, дотоодод хэрэглэгдэх энгийн төлбөрийн карт юм.

Тайлант онд тус банк нь 2008 онд анх нэвтрүүлсэн анхны хоёр валют /USD, EUR/ бүхий МастерКартыг олон улсын хамгийн орчин үеийн төлбөрийн картын нууцлал болох EMV чип технологитой карт болгох ажлыг амжилттай гүйцэтгэж карт эзэмшигчиддээ картыг нь үнэ төлбөргүй солих ажлыг хийллээ. МастерКартын үндсэн 4 төрлийн дебит болон кредит карт /Энгийн, Алтан, Бизнес, Платинум/-уудыг EMV чип технологид шилжүүлснээс гадна харилцагч байгууллагын бизнесийг дэмжих, өөрийн нэрийн картын төрлийг нэмэгдүүлэх, харилцагчдын хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор Монгол улсад анх удаа урьдчилсан төлбөрт картыг /prepaid card/ үндсэн утгаар нь харилцагч олондоо гаргалаа.

“М-Ойл” ХХК-тай хамтран шатахууны анхны урьдчилсан төлбөрт бөгөөд онооны картыг “М-Ойл” ХХК-ийн харилцагчдад зориулан зах зээлд нэвтрүүллээ. Энэхүү карт нь шатахуун худалдан авсан үнийн дүнгийнхээ нэг хувьд оноо цуглуулах бөгөөд хуримтлагдсан оноогоороо М-Ойл компанийн тос, тослогооны барааг хөнгөлөлттэй үнээр авах боломжтой юм. Энэхүү бүтээгдэхүүн нь дэлхийд алдартай Acer корпорацийн Лоялти системийн шийдэл бүхий ХХБ-наас банкнаас гаргасан 2 дахь төлбөрийн карт билээ. 2011 оны 12 сард ХХБ нь шинэ харилцагч нэмэгдүүлэх, бэлэн бус төлбөр тооцоог дэмжих, харилцагчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, төлбөрийн картын шинэ төрлийг таниулах зорилготойгоор өөрийн нэрийн урьдчилсан төлбөрт Бэлэглэлийн картыг зах зээлд нэвтрүүлсэн билээ. Энэхүү карт нь харилцагчтай гэрээ байгуулж, захиалга хүлээн авах шат дамжлагыг хялбарчилсан давуу талтай бөгөөд 20,000-1,000.000 төгрөгийн хооронд хүссэн дүнгээр картын дансыг цэнэглэж, дотны хүндээ бэлэг болгон барих боломжтой онцлог карт боллоо.

2011 оны 9 дугээр сард Монгол банкнаас Монголын анхны Үндэсний төлбөрийн карт гаргах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлсэнээр Монгол улын арилжааны банкууд, Монгол хүн өөрийн Үндэсний төлбөрийн картыг ашиглах түүхэн ач холбогдол бий болсон. Үүний хүрээнд ХХБ нь Үндэсний “₮” брэндийн төлбөрийн карт гаргах анхны банкны зөвшөөрлийг авч Үндэсний “₮” картын нууцлал бүхий hologram, логог өөрийн картын нийлүүлэгч байгууллагаараа дамжуулан дэлхийд алдартай, Виза, МастерКартын hologramыг хөгжүүлэгч KURZ компаниар Trustseal® технологи ашиглан хийлгэж өөрийн нэрийн Үндэсний карт гаргах бэлтгэл ажлыг хийсэн нь картын нууцлалын хувьд дэлхийн жишигт хүрсэн, цаашид Монголын бусад банкууд авч хэрэглэх боломжтой чухал үйл ажиллагаа болсон гэж үзэж байна. Энэхүү карт нь Монгол улсад хэрэглэгдэх дотоодын карт байх бөгөөд цааашдаа олон улсын төлбөрийн сүлжээнд нэгдэж үйлчлүүлэх боломжтой гэж төлөвлөж байна.



Өнгөрсөн 2 жил ХХБ нь өөрийн картын нууцлал, харилцагчийн гүйлгээний мэдээллийн нууцлалд онцгой анхаарч соронзон тузат картаас EMV чип карт руу шилжих, түүнчлэн өөрийн карт эзэмшигчдийн болоод интернэт үйлчилгээний байгууллагыг болзошгүй эрсдлээс сэргийлэх, луйврын гүйлгээний 3D Secure технологийг бууруулах зорилгоор Verified by Visa, MasterCard Secure Code интернэт гүйлгээний 3D Secure технологийг нэвтрүүлж ажиллахын зэрэгцээ хамтарсан картаар өөрийн харилцагч байгууллагынхаа бизнесийг дэмжиж харилцагчдад илүү өргөн хүрээтэй төлбөрийн картыг санал болгон зах зээлд гаргахад түлхүү анхаарч ажиллалаа.

Тайлант он эцсээр нийт карт эзэмшигчийн тоо 160 000-д хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 28 хувиар өссөн бол карт бизнестэй холбоотой орлого өмнөх оныхоос 53 хувь өсөж байгаа нь банкны нийт шимтгэлийн орлогын 26 хувийг хангасан байна.

Харилцагчийн нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 63.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 1.6 дахин нэмэгдсэн нь банк картын дансны үлдэгдэлд үлдэгдэл үл хамааран сарын 0,3 хувийн хүү олгодогтой холбон тайлбарлаж болно.

## ATM

ХХБ нь 2001 онд өөрийн ATM-ны сүлжээг бий болгон ажиллаж эхэлсэн бөгөөд 2011 оны байдлаар нийт 77 ATM байгаагаас УБ хотод 60, орон нутагт 17 ATM тус тус карт эзэшигчидэд үйлчилж байна. Тайлант онд ATM-ны үйлчилгээний хувьд олон улсын томоохон брэнд болох Discover, Diners Club International, PULSE-ийн сүлжээний картуудыг өөрийн сүлжээнд хүлээн авах боломжийг хангасанаар гадны карт эзэмшигч, ялангуяа Америкийн карт эзэмшигч зочид, жуулчидад чухал ач холбогдолтой үйлчилгээ боллоо. Мөн цахим банкны хөгжлийн бодлоготойгоо уялдан ATM дээр гар утсаа ашиглан бэлэн мөнгө авах техникийн боломжийг "Most Money" төслийн хүрээнд шийдэж бэлтгэл ажлыг хангалаа.



## POS

ХХБ-ны төлбөрийн картыг төлбөрт хүлээн авах бизнес 1991 оноос эхлэлтэй бөгөөд анх 1991 онд AMEX, 1993 онд Visa, MasterCard, 1994 онд JCB картуудыг өөрийн сүлжээнд, салбар тооцооны төв, харилцагч байгууллагаар дамжуулан төлбөрт хүлээн авч үйлчилж эхэлсэн. Улмаар 2010 онд Монгол банкны Төлбөр тооцооны банк дундын төвд холбогдох Монголын улсын арилжааны бүх банкны бүх төрлийн төлбөрийн картыг хүлээн авдаг болсон бол 2011 онд ПОС терминал дээр гар утсыг төлбөрийн хэрэгсэл болгон ашиглах боломжийг нээлээ.

Тайлант онд ПОС-ын гүйлгээ 2010 оныхоос 40 хувиар нэмэгдэж нийт картын үйл ажиллагааны шимтгэлийн орлогын 20 хувийг эзэлж байна. ХХБ нь өөрийн салбарын болоод, ATM, ПОС-ын сүлжээг өргөтгөх болон бусад цахим бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхээс гадна бусад банкуудад картын системийн болоод бизнесийн зөвлөгөө үзүүлэх замаар тэдгээрийн бизнесийг дэмжих, зарим бус нутгийн харилцагчдад хүрч үйлчилэхдээ тэдгээрээр дамжуулан үйлчлэх боломжийг хангах зорилгоор Монгол улсын арилжааны банкуудад "гуравдагч этгээдийн үйлчилгээ"-г үзүүлдэг. Энэхүү үйл ажиллагаа нь бусад банкуудыг дэд гишүүнээр элсүүлэх, тэдгээрт программ, хангамж, системийн дэмжлэг үзүүлэх, бизнес зөвлөгөө өгөх үйлчилгээ байх бөгөөд 2011 оны байдлаар ХХБ-ны дэд гишүүн банкаар Улаанбаатар хотын банк, Капитал, Эрэл банкууд хамтран ажиллаж байгаа ба цаашлаад Хас банк, Капитрон болон бусад арилжааны банкууд хамтран ажиллахаар ярилцаж байна. Энэхүү үйлчилгээнээс олох орлого 2011 оны байдлаар картын нийт орлогын 5 хувийг эзэлж байна.

Тайлант онд ХХБ нь өөрийн сүлжээнд хүлээн авч үйлчлэх картын нэр төрлийг нэмэгдүүлэх, бусад банкны сүлжээг ашиглан өөрийн харилцагчиддаа хүрч үйлчлэх талаар чиглэн ажиллахын зэрэгцээ өөрийн стандарт үйлчилгээнүүд болох интернэт худалдаа, үүрэн телефоны оператор болон бусад биллингийн компанийн төлбөрийг өөрийн ATM, салбар, интернэт үйлчилгээний байгууллагуудаар цуглуулан авах зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлж байна.

## Төлбөрийн картын зах зээл дэхь ХХБ-ны байр суурь

ПОС терминал	25%
ПОБ терминал	7%
АТМ терминал	12%
Идэвхтэй карт эзэмшигчдийн тоо	36%

ПОС терминал	Гүйлгээний дүн	32%
	Гүйлгээний тоо	28%
ПОБ терминал	Гүйлгээний дүн	18%
	Гүйлгээний тоо	12%
АТМ терминал	Гүйлгээний дүн	16%
	Гүйлгээний тоо	13%

## Интернэт банкны үйлчилгээ:

ХХБ нь өөрийн 3 шатлалт хамгаалалтын систем бүхий орон зай, цаг хугацаанаас үл хамаарсан үйлчилгээний өргөн сонголт, боломж бүхий интернэт банкны үйлчилгээг харилцагчиддаа үзүүлсээр ирсэн бөгөөд интернэтээр хийгдсэн гүйлгээний тоо өмнөх оноос 14% хувиар өсчээ. Харилцагчид интернэт банкаар дараах төрлийн гүйлгээ хийх боломжтой. Үүнд:

- > Дансны хуулга, гүйлгээг харах;
- > Банкнаас захидал, мэдээлэл хүлээн авах;
- > Банк руу захидал илгээх;
- > Хугацаатай хадгаламжийн хугацааг сунгах;
- > Валютын арилжаатай гүйлгээ хийх;
- > Өөрийн данс хооронд шилжүүлэг хийх;
- > Банк доторх шилжүүлэг хийх;
- > Гадаад дотоод шилжүүлэг хийх;
- > Банк хооронд шилжүүлэг хийх;
- > Төлбөрийн даалгавар, нэхэмжлэхийн төлбөр;
- > Биллингийн төлбөр;


## Интернэт банкаар хийгдсэн гүйлгээ

	2009	2010	2011
Гүйлгээний тоо /мянган ширхэг/	48.34	59.19	67.50
Гүйлгээний дүн /тэрбум төгрөг/	185.13	311.00	360.79

Мобайл банкны үйлчилгээ: Интернэт банкны мобайл хувилбар болох гар утасны интернэт буюу GPRS технологид суурилсан WAP, JAVA гэсэн 2 хувилбараар Мобайл банкны үйлчилгээг 2011 онд харилцагчиддаа санал болголоо. Энэхүү үйлчилгээг банкны бүх харилцагчдад санал боломжтой болсоноор харилцах, хадгаламж, картын данс эзэмшигч бүр энэхүү үйлчилгээг авах өргөн боломжийг бүрдүүлсэн юм. 2011 онд мобайл банкны үйлчилгээг ашиглан гарсан гүйлгээ өмнөх онтой харьцуулахад 11 дахин өссөн ба гүйлгээний мэдээллийг дор үзүүлэв.

	2010	2011
Гүйлгээний тоо /мянган ширхэг/	1.6	18.6
Гүйлгээний дүн /тэрбум төгрөг/	0.17	2.62

Мөн тайлант онд ХХБ нь гар утсыг төлбөрийн хэрэгсэл болгон ашиглах "Most Money" төслийг эхлүүлж уг ажлын хүрээнд гар утсаараа банкны ATM, энгийн болон интернэт үйлчилгээний байгууллага дээр үйлчлүүлэх боломжийг нээн өгсөнөөр ирээдүйн мобайл төлбөр тооцооны эхлэлийг тавьлаа.



A photograph of two men in business attire. One man, wearing a light-colored suit, is holding a blue folder and looking down at it. The other man, in a dark suit, is standing beside him, also looking at the folder. They appear to be in an office setting with large windows in the background.

ГАДААД  
ХАРИЛЦААНЫ  
БАНКНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГАА



# ГАДААД ХАРИЛЦААНЫ БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОУБГ нь ХХБ-ны гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай хийж буй харилцааг хариуцан ажилладгийн хувьд олон улс дахь ХХБ-ны нэр хүндийг өсгөн, гадаадын банк санхүүгийн байгууллагуудтай хийж буй хамтын ажиллагааг өндөр түвшинд хүргэх, гадаад төлбөр тооцоо, худалдааны санхүүжилт болон тухайн банк санхүүгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн боломжуудыг харилцагчдад нээн өгөх нь зорилготой. Бид тайлант хугацаанд уг зорилгын хүрээнд 150 гаруй харилцагч банк, санхүүгийн байгууллагууд болон бусад шинэ санхүүгийн байгууллагуудтай харилцаагаа өргөжүүлэх тал дээр түлхүү анхаарч, Хятадын банкны Хонг Конг дахь салбар (Bank of China, Hong Kong Branch), ВТБ Москва (VTB Moscow), CITI Bank, Unicredit Moscow банк, Renaissance Securities зэрэг банк санхүүгийн байгууллагуудтай харилцан дансдыг нээж, Хятадын Хөдөө аж ахуйн банк (Agricultural Bank of China), Бугат хотын арилжааны банк (Baoshang Bank)-уудтай импортын санхүүжилтийн гэрээ, ХБНГУ-ын Commerzbank-тай "Master Agreement Trade Finance Facility" гэрээнд тус тус гарын үсэг зурж, Хятад болон Европын холбооны улс төдийгүй бусад улсуудаас хийж буй импортыг санхүүжүүлэх боломжийг нэмэгдүүллээ.

Тайлант онд Олон улсын банкны газар нь төслийн санхүүжилт, хамтын санхүүжилт, худалдааны санхүүжилтийн хүрээнд гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай үр ашигтай хамтран ажиллаж, 98.0 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн нь 2010 оны 42.0 тэрбум төгрөгтэй харьцуулахад 2.3 дахин өссөн байна. Энэ нь банкны татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийн төрөл хэлбэрүүдийг олон талтай болгох болон өөрийн харилцагчдад хямд эх үүсвэрт суурилсан бага хүйтэй зээл олгоход чухал хувь нэмрээ оруулаа.

Мөн 2011 онд ХХБ-наас уул уурхай, хөрөнгө оруулалтыг дэмжих, харилцагчдад банкны бүтээгдэхүүн үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл зөвлөгөө өгөх зорилгоор хурал чуулгануудыг зохион байгуулж, ивээн тэтгэгчээр тус тус оролцлоо. Үүнд: Coal Mongolia 2011 (2-р сард), Монголын Эдийн Засгийн Форум (3-р сард), Introduction of Comprehensive Interbank Import Credit Facility with Korea Exim bank (4-р сар), Listing in Hong Kong (4 сард), Frontier Capital Raising Conference (6-р сард), Singapore Mongolian Business Forum (6-р сард), Korea's economic success: Strategies, challenges and lessons for Mongolia (8 сард), Discover Mongolia (9-р сард), Mongolia Trade & Commodity Finance Conference (10-р сард), Metals Mongolia 2011 Forum (11-р сард).

## Гадаад төлбөр тооцоо

Худалдаа, хөгжлийн банк нь гадаад төлбөр тооцооны өргөн сүлжээтэй бөгөөд тайлант хугацаанд гадаадын 27 банкинд байршуулсан 14 валютын нийт 38 дансаараа дамжуулан харилцагчдын төлбөр тооцоог амжилттай гүйцэтгэж ирлээ. Бид ING банкин дахь дансаараа дамжуулан 14 валютаас гадна, бусад валютаар харилцагчийн гүйвуулгыг хурдан шуурхай, найдвартай дамжуулж байна. Мөн энэ онд Хятадын банкны Хонг Конг дахь салбар (Bank of China, Hong Kong Branch), ВТБ Москва (VTB Moscow) банкууд дээр юань, рубль, ам.долларын дансдыг нээллээ.

2011 онд ХХБ-ны гадаад гүйвуулгын хэмжээ эрчимтэй өссөнийг улс орны хувьд судалж үзвээс Монгол улсын голлох гадаад худалдааны түнш орнууд болох АНУ, Австрали, Австри, Арабын Эмират, Бельги, Гонг-Конг, Голланд, Канад, ОХУ, Польш, Сингапур, Тайланд, Турк, Хятад, Чех, Энэтхэг, Япон, Солонгос зэрэг улс орнууд дээгүүр орж, өсөлтийн хувь тус бүр дунджаар 70%-тай байна.



Мөн Монгол улсын эдийн засаг хурдацтай өсч хөрөнгө оруулагчдын сонирхол өсөн нэмэгдэж буйтай холбоотойгоор гадаадын нэр хүндтэй банк, санхүүгийн байгууллагууд Монгол төгрөгийн дансыг ХХБ-нд нээх сонирхолтой болсон байна. Үүний үр дүнд тайлант онд ХХБ нь гадаадын банк санхүүгийн байгууллагын төгрөг, ам.доллар, юаний нийт 10 дансдыг нээж, төлбөр тооцоог гүйцэтгэгч банкаар ажиллаж байна.

## Гадаад худалдааны санхүүжилт

Худалдааны санхүүжилт нь Худалдаа, хөгжлийн банкны бас нэгэн давуу тал бөгөөд энэ ч утгаараа олон улсын худалдааны санхүүжилтийн GTR сэтгүүлээс дэлхийн томоохон банкуудын дунд явуулсан санал асуулгаар “Монголын 2011 оны худалдааны санхүүжилтийн хамгийн шилдэг банк”-аар тодроод байна. Бидэнд худалдааны санхүүжилтийн арвин туршлага, харилцагчдад хандсан хамгийн уян хатан үйлчилгээ, хамгийн олон гарцууд бий.

Тайлант хугацаанд Монголын эдийн засаг үсрэнгүй хөгжиж байгаатай уялдан гадаад худалдааны эргэлт 2010 онтой харьцуулахад 83%-иар өссөн байгаагаас импортын бараа бүтээгдэхүүнд уул уурхайн тоног төхөөрөмж, барилгын материал, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүхий эд; экспортын бараа бүтээгдэхүүнд уул уурхайн бүтээгдэхүүн, малын түүхий эд, мах махан бүтээгдэхүүн голлох өсөлттэй байна. Харилцагчид худалдааны санхүүжилтийн хэрэгслүүд болох аккредитив, баталгаа, инкассын талаар өргөн мэдлэгтэй болж, тэдгээрийг сонгон хэрэглэх нь нэмэгдсээр байгаа бөгөөд 2011 онд ХХБ-аар дамжин хэрэгжсэн худалдааны санхүүжилтийн нийт дүн буюу нээгдсэн импорт, экспортын аккредитив, баталгаа, инкассын дүн 42%-иар өссөн үзүүллэлттэй байна.

Уг өсөлтийг улс орны хувьд авч үзвээс Щвейцар, Хятад, Турк, Тайланд, Сингапур, Хонг Конг, Англи зэрэг улсууд өсөлтийн хувиараа дээгүүр орж байгаагаас гадна АНУ, Герман, ОХУ, Өмнөд Солонгос, Энэтхэг, Япон зэрэг улс орнуудтай холбоотой гарч буй гүйлгээнүүд нийт гүйлгээнд томоохон хувь хэмжээг эзэлж байна.

Монгол улсын уул уурхайн сектор эрчимтэй хөгжиж байгаатай холбоотойгоор экспортын хэмжээ эрчимтэй нэмэгдэж байгаа бөгөөд үүнийг дагаад ХХБ руу нээгдэж буй экспортын аккредитивын тоо хэмжээ 2007 оноос жилийн дундаж өсөлт 66.8%-тай байна.

## Импортын санхүүжилт



Худалдаа, хөгжлийн банк нь гадаад худалдааг дэмжих, харилцагчдад хөнгөлттэй зээл олгох зорилгын дагуу гадаадын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран импортын санхүүжилтийн үйлчилгээг хүргэсээр ирсэн. 2011 онд харилцагчдад олгосон импортын санхүүжилтийн хэмжээ 2010 оны 6.8 сая ам.доллараас даруй 3.1 дахин өсж, 20.8 сая ам.долларт хүрсэн байна.

Тайлант хугацаанд UBS Bank, Citibank, Bank of China, Deutsche Bank, SMBC Bank зэрэг банкуудтай хамтын ажиллагаагаа худалдааны санхүүжилтийн бизнесээр өргөжүүллээ. Тайлант оны эцсийн байдлаар тус банкинд гадаадын 30 банк, санхүүгийн байгууллагаас нийтдээ 177 сая орчим ам.долларын худалдааны санхүүжилтийн зээлийн шугамыг олгосон нь 2010 онтой харьцуулбал 27%-аар өссөн үзүүллэлтэй байна

Худалдааны санхүүжилтийн өсөлт



Экспортын аккредитив



## Байгаль орчин, жижиг дунд, микро бизнесийг дэмжих төсөл хөтөлбөрүүд



### Төслийн санхүүжилт

ХХБ нь жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлж ажиллах зорилгоор Дэлхийн томоохон банкуудаас хэрэгжүүлж буй дамжуулан зээлдэх санхүүжилтийн хөтөлбөрүүдэд хамрагдан ажиллаж байна. Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Японы JICA, Германы KFW банк болон Монголын Засгийн газар хоорондын хэрэгжүүлж буй жижиг дунд үйлвэрлэл, байгаль орчныг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд тайлант хугацаанд нийт 19 харилцагчид 605,530 евро, 1,502,793 ам.доллар, б тэрбум төгрөгийн зээлийг шинээр олгосон буюу 2010 онтой харьцуулахад 310%-иар өссөн байна. Эдгээр үзүүлэлтууд цаашид өсөх төлөвтэй байгаа бөгөөд уг төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх нь Монгол улсын жижиг, дунд үйлдвэрлэлд томоохон хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

### Хамтын санхүүжилт

ХХБ нь Монгол улсдаа төдийгүй гадаадын банк санхүүгийн байгууллагуудтай Хамтын санхүүжилтийн үйлчилгээг үзүүлэгч анхны банк бөгөөд 2011 онд ХХБ нь Монголын таван арилжааны банктай хамтран Монгол улсын хөрөнгийн биржид зориулан зохион байгуулж буй 14.22 сая ам.долларын Хамтын санхүүжилтийн зээлийн ерөнхий зохион байгуулагчаар оролцлоо. Мөн тайлант онд Австрийн VTB банктай хамтран 65 сая ам.доллар болон 50 тэрбум төгрөгийн хамтын санхүүжилтын зээлийг олгосон нь 2010 оны 9 сая ам.доллартай харьцуулахад 11.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Монголын эдийн засаг уул уурхай, барилга болон дэд бүтцийн секторуудад эрчимтэй хөгжиж байгаатай уялдан харилцагчийн зээлийн хэрэгцээ мэдэгдэхүйц өссөн нь хамтын санхүүжилтийн хэрэгцээг нэмэгдүүлж байна.

### Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа

Худалдаа, Хөгжлийн банк нь Олон улсын санхүүгийн зах зээлд Европын Дунд Хугацааны Үнэт Цаас (ЕДХҮЦ) гаргах 300 сая ам. долларын хөтөлбөрийн хүрээнд 2007 оны 1-р сард ЕДХҮЦ-ны 150 сая ам. долларын хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2010 онд эргэн төлөгдөх 75 сая ам. долларын бондыг анх удаа амжилттай борлуулсан билээ.

2010 оны 1-р сард анхны бондоо хугацаанд нь амжилттай эргүүлэн төлж, бага хүйтэй гадаад эх үүсвэр дахин татах зах зээлийн тааламжтай нөхцлийг хүлээж байсан ба 2 дахь удаагийн бондоо илүү таатай нөхцөлтэйгээр 3 жилийн хугацаатайгаар 150 сая ам.долларын бонд болон өөрийн хөрөнгөө өсгөх зорилгоор 5 жилийн хугацаатай, 25 сая ам.долларын хоёрдогч үнэт цаасыг тус тус гаргалаа.

Анхны бондоо хугацаанаас нь өмнө амжилттай төлсөн явдал нь гадаадын хөрөнгө оруулагчдад ХХБ-ны найдвартай, тогтвортой үйл ажиллагааг батлаад зогсохгүй, тус банкны эрсдэлийг зөв үнэлэх, зээлжих чадварын үзүүлэлтүүд нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээр татаж, 2 дахь удаагийн бондын борлуулалтад эерэгээр нөлөөсөн. ХХБ-ны бондыг худалдан авах захиалгын хэмжээ 420 сая ам. долларт хүрсэн нь борлуулах хэмжээнээс 2.8 дахин их үзүүлэлт байсан юм.

2011 оны 5-р сард ХХБ-ны 5 сая ам.долларын 5 жилийн хугацаатай хоёрдогч өглөгийг Хонконгийн хөрөнгө оруулагчид худалдан авсан байна. Эдгээрээс үзэхэд Худалдаа, хөгжлийн банкны нэр хүнд Монголд төдийгүй олон улсад өсөн нэмэгдэж, хөрөнгө оруулагчдын сонирхол өсөн нэмэгдсэн байна.

## ХХБ-ны гадаад төлбөр тооцоо

2011 оны байдлаар Монгол улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 11,307.2 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 83.1%-иар өсчээ. Тайлант онд ХХБ-ны гадаад төлбөр тооцооны нийт хэмжээ 5,424.5 сая ам.долларт хүрсэн бөгөөд өнгөрсөн онтой харьцуулбал 57.2%-ийн өсөлттэй байна. ХХБ нь тайлант онд Монгол улсын гадаад худалдааны төлбөр тооцооны 47.97%-ийг дангаараа гүйцэтгэсэн байна.

Тайлант хугацаанд нийт экспортын гүйлгээ өнгөрсөн онтой харьцуулахад 99.92%, импортын 31.33%-иар тус тус өссөн байна.

Гадаад орнуудаас хүлээн авсан болон гадаад руу шилжүүлсэн шилжүүлгийн хэмжээ тогтмол өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд 2011 оныг суурь онтой харьцуулбал хүлээн авсан гадаад шилжүүлэг 164%-иар, гадаад руу шилжүүлсэн шилжүүлэг 176%-иар тус тус өссөн байна.

Уул уурхайд суурилсан эдийн засгийн эрчимтэй өсөлтийн үр дүнд хөрөнгө оруулалт, барилгын материал, тээврийн хэрэгсэл болон үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах зориулалттай гадаад төлбөр тооцоо цаашид өсөх хандлагатай байна.


Тайлант онд дэлхийн 90 гаруй улс орнуудтай гадаад төлбөр тооцоог гүйцэтгэсэн байна.

Гадаад орнууд руу шилжүүлсэн буюу гадаад худалдааны импортыг харуулах нийт гүйлгээний 75%-ийг Америк, Гонг-Конг, Канад, ОХУ, Өмнөд Солонгос, Хятад, Щвейцари зэрэг улс орнуудтай хийсэн төлбөр тооцоо эзэлж байгаа бөгөөд үүнээс 21.6%-ийг Хятад, 14%-ийг АНУ, 12%-ийг Гонг-конг улстай тус тус хийсэн байна. Мөн гадаад орнуудаас хүлээн авсан буюу гадаад худалдааны экспортыг харуулах гүйлгээний нийт дүнгийн 60%-ийг Америк, Англи, Гонг-Конг, Латви, ОХУ, Өмнөд Солонгос, Хятад, Щвейцари улсуудаас хүлээн авсан төлбөр тооцоо эзэлж байгаагийн 40%-ийг Гонг-Конг, 11%-ийг Хятад, 6%-ийг АНУ-тай хийсэн төлбөр тооцоо тус тус эзэлж байна.


Гадаад орнууд руу шилжүүлсэн шилжүүлгийг зориулалтаар харуулбал




Нийт шилжүүлэгт эзлэх хувиар



Гадаадаас хүлээн авсан шилжүүлгийн өсөлтийн хэмжээ хувиар



Гадаад руу шилжүүлсэн шилжүүлгийн өсөлтийн хэмжээ хувиар





ТИ ДИ БИ  
КАПИТАЛ

# ТИ ДИ БИ КАПИТАЛ

## КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Ти Ди Би Капитал ХХК нь Монголын банк санхүүгийн салбарт тэргүүлэгч Худалдаа хөгжлийн банкны 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани бөгөөд хөрөнгө оруулалтын банкны цогц үйлчилгээг харилцагчиддаа хүргэхээр Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан Монголын хөрөнгийн биржийн гишүүн байгууллага юм.

Монгол улсын эдийн засгийн хурдацтай өсөлт, уул уурхайн салбарын хөгжилтэй уялдан Монгол улсын иргэн бүр эх орныхоо баялгаас хувь хүртэх боломжтой болж буй энэ үед Ти Ди Би Капитал ХХК нь Худалдаа хөгжлийн банкны 21 гаруй жилийн хугацаанд хуримтлуулсан туршлага, олон улсын банк санхүүгийн зах зээл дээрх нэр хүнд, харилцаа холбоо болон дотоодын зах зээл дээрх тэргүүлэх байр сууринд тулгуурлан Монгол улсын хөрөнгийн зах зээлд өөрийн бодит хувь нэмрийг оруулахаар үйл ажиллагаагаа эхэллээ.

2008	2010	2011
Дотоодын банкуудаас анх удаа Худалдаа хөгжлийн банк Хөрөнгө оруулалтын банкны газрыг байгууллаа.	Худалдаа хөгжлийн банк нь Гадаад харилцаа, хөрөнгө оруулалтын банкны газрын бүтцийг шинэчлэн хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагааг Ти Ди Би Капитал ХХК-д шилжүүллээ.	Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооноос андеррайтер, брокер болон бусад хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлүүдийг авлаа. Мөн Монголын Хөрөнгийн биржид гишүүнээр элсэв.

Манай компани нь дараах төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчиддаа хүргэж байна.

- > Корпорацийн санхүүжилт
- > Брокерийн үйлчилгээ
- > Активын удирдлага
- > Судалгаа, зөвлөх үйлчилгээ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үүсгэн байгуулагчаас томилогдсон, хувьцаа эзэмшигчдийн нэрийн өмнөөс гүйцэтгэх удирдлагад хяналт тавих үүрэгтэй ажилладаг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Ноён Д.Эрдэнэбилгэ (ТҮЗ-ийн Дарга), Ноён Б.Мэдрээ (ТҮЗ-ийн гишүүн) болон Ноён Рандольф С.Коппа (ТҮЗ-ийн гишүүн) нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.



## УДИРДЛАГЫН БАГ

Ноён Рандольф Коппа, Ерөнхийлөгч




Ноён Р.Коппа нь сүүлийн 40 гаруй жилийн турш олон улсын банк санхүүгийн салбарт ажилласан туршлагатай банкир бөгөөд тэрээр Япон, Хонг Конг, Сингапур, Итали, Польш АНУ, Нидерланд зэрэг дэлхийн 12 улсад ажиллаж байжээ. Худалдаа хөгжлийн банкинд ажиллаж эхлэхээсээ өмнө тэрээр Нидерландын ING банкны удирдах албан тушаалд 15 жилийг өнгөрөөжээ. Ноён Р.Коппа хөгжиж буй зах зээл дэх арилжааны болон хөрөнгө оруулалтын банкны салбарт арвин туршлагатай.

Ноён О.Орхон, Гүйцэтгэх Захирал



Ноён О.Орхон нь 2007 оны 1 дүгээр сараас хойш Худалдаа хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогчоор ажиллаж байна. Тэрээр өмнө Худалдаа хөгжлийн банкинд эдийн засагч, ахлах эдийн засагч, мөн Худалдаа хөгжлийн банк болон Улаанбаатар хотын банкуудад гүйцэтгэх захирлын орлогч, гүйцэтгэх захирааар тус тус ажиллаж байжээ. О.Орхон санхүүгийн шинжилгээ, төлөвлөлт, арилжаа, зээлийн санхүүжилт, оффшор хэлцэл, өрийн болон хувьцааны санхүүжилтийн чиглэлд 15 жил ажилласан туршлагатай мэргэшсэн банкир юм.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЦ



# 2011 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- > Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авав.
- > Монголын Хөрөнгийн биржид гишүүнээр элсэв.
- > Брокерын үйлчилгээний төвөө нээв.
- > Монголын Хөрөнгийн биржийн үнэт цаасны нийт арилжааны 23 хувийг буюу 105.8 тэрбум төгрөгийн гүйлгээг дангаар гүйцэтгэв.
- > Үндэсний компаниудтай хамтран ажиллаж, 93.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт болон санхүүгийн эх үүсвэрийг харилцагч нартаа татан төвлөрүүлж өгөв.

## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Корпорацийн санхүүжилт


Корпорацийн санхүүжилт буюу андеррайтерийн үйлчилгээний хүрээнд бид харилцагч нартаа дараах төрлийн үйлчилгээг санал болгож байна.

- > Хувьцааг нийтэд нээлттэй санал болгох(IPO)
- > Өрийн бичиг болон хоёрдогч өглөг
- > Хаалттай хүрээн дэх хөрөнгө оруулалт
- > Үүсмэл хэрэгслийн санхүүжилт

Бид хувьцааг нийтэд нээлттэй санал болгох ажлын бэлтгэл үеийн санхүүжилт, уул уурхайн хайгуулын ажлын болон экспортын урьдчилгаанд зориулагдсан хөрөнгийн эх үүсвэрийг харилцагч нартаа татан төвлөрүүлж өгөөд байна. Мөн олон улсын нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын банкуудтай хамтран, үндэсний компаниудын хувьцаа, бонд гаргах ажлыг зохион байгуулахаар ажиллаж эхлээд байна.

2011 онд бид Монгол улсын эдийн засгийн өсөлт хөгжилтөд хувь нэмэр оруулахуйц үндэсний компаниудтай хамтран ажиллаж, төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай нийт 93.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг дараах хэлбэрүүдээр татан төвлөрүүлж өгөв. Үүнд:

- > Хоёрдогч өглөг: Харилцагчийн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор хаалттай хүрээнд 7 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийг гаргав.
- > Хаалттай хүрээн дэх хөрөнгө оруулалт: Уул уурхайн хайгуул, олборлолтын ажил болон хувьцааг олон нийтэд санал болгох бэлтгэл үеийн санхүүжилтэд зориулан уул уурхайн 2 төсөлд нийт 37.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хаалттай хүрээнд амжилттай хийж гүйцэтгэв.
- > Хамтын эх үүсвэрийн зээл: Уул уурхайн салбарын төслийн хүрээнд харилцагчдын бизнесийн үйл ажиллагаанд зориулан 48.9 тэрбум төгрөгийн хамтын эх үүсвэрийн зээл авах ажлыг зохион байгуулав.



## Брокерийн үйлчилгээ


Үнэт цаасны зуучлал буюу брокерийн үйл ажиллагааны хүрээнд дараах үйлчилгээг харилцагч нартаа санал болгож байна.

- > Үнэт цаасны зуучлал
- > Үнэт цаасны судалгаа, мэдээлэл
- > Бусад

Монгол улсын эдийн засгийн болон уул уурхайн салбарын өсөлт хөгжилтэй холбоотойгоор олон улсын хөрөнгө оруулагчдын Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө оруулалт хийх сонирхол ихээр нэмэгдэж байна. Бид эдгээр хөрөнгө оруулагчдад энэхүү боломжийг нээх, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийн хөрөнийн зах зээлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэн, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор брокерийн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлж эхлээд байна.

Мөн үндэсний томоохон аж ахуйн нэгж, байгууллагууд болон иргэд Хонг Конг, Австрали, Лондон болон Торонто зэрэг дэлхийн томоохон хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж буй үнэт цаасны арилжаанд хөрөнгө оруулалт хийх сонирхолд үндэслэн олон улсын арилжааг эхлүүлэхээр бэлтгэл ажлуудыг хангаж байна.

Бид 2011 оны 7-р сарын 22-ны өдөр брокерийн үйлчилгээний төвөө нээн ажиллуулсан бөгөөд тайлант хугацаанд нийт 3,000 орчим харилцагчдийн үнэт цаасны дансыг нээгээд байна. Мөн тайлант хугацаанд харилцагчидас 120 орчим арилжааны захиалга хүлээн авч биелүүлсэн ба 72.6 сая төгрөгийн хувьцааны арилжаа, 105.8 тэрбум төгрөгийн бондын арилжаа хийсэн.



## Мэргэжлийн судалгаа, мэдээлэл

Харилцагч нартаа хөрөнгийн зах зээлийн талаар мэдээллийг түргэн шуурхай, тасралтгүй хүргэх зорилгоор дараах төрлийн мэдээ, мэдээллийг бэлтгэн гаргаж байна.

- > Макро эдийн засаг
- > Салбарын судалгаа
- > Монголын Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хувьцаат компаниудын судалгаа
- > Олон улсын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй Монголд үйл ажиллагаа явуулдаг компаниудын судалгаа
- > 7 хоног тутмын зах зээлийн мэдээлэл
- > Өдөр тутмын арилжааны мэдээ

Бид хөрөнгө оруулагчдад эдийн засаг, зах зээлийн өнөөгийн байдал, хэтийн төлөвийн талаар цаг үеийн бодит мэдээллийг хүргэхээс гадна эдийн засгийн томоохон салбарын судалгаа, Монголын болон олон улсын биржүүдэд бүртгэлтэй Монголд үйл ажиллагаа явуулдаг компаниудын талаар судалгаа, шинжилгээг хийн харилцагчиддаа хүргэхээр зорин ажиллаж байна.

## Бусад үйлчилгээ

Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах үүднээс харилцагчидад хөрөнгийн зах зээлийн талаар анхан шатны мэдлэг олгох, үнэт цаасны арилжаанд оролцоход шаардлагатай мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулж байна. Уг сургалтыг 7 хоног бүр үйлчилгээний төв дээр зохион байгуулахаас гадна байгууллага, хамт олны хүсэлтээр байгууллагууд дээр нь очиж тухайн байгууллагын ажилтнуудыг мэдлэг, мэдээллээр хангаж байгаа нь харилцагч нарын маань талархлыг хүлээж байгаа билээ.

Харилцагч хүссэн үедээ дансны мэдээллээ авах, дансаа хянах зорилгоор интернэт дансны үйлчилгээг нэвтрүүлээд байна. Мөн харилцагч нарын хүсэлтээр хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах зэрэг бусад үйлчилгээг харилцагчиддаа хүргэж эхэллээ.





ХӨРӨНГӨ  
ЗОХИЦУУЛАЛТЫН  
УДИРДЛАГА

# ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН УДИРДЛАГА

## Гадаад валютын арилжаа

ХХБ байгуулагдсан цагаасаа эхлэн гадаад төлбөр тооцоо, валют, үнэт металлын арилжааны үйл ажиллагааг голлох чиглэлээ болгож ирсэн ба дээрх үйл ажиллагаануудаар дотоодын зах зээлд томоохон байр суурь эзэлсэн хэвээр байна. Өнгөрсөн 2011 онд валют арилжааны харилцагчдын тоо болон арилжааны эргэлтийн хэмжээг нэмэгдүүлэх зорилт тавин ажилласны үр дүнд валют арилжааны нийт эргэлт өмнөх оноос 26.5 хувиар нэмэгдэж, дотоодын валютын зах зээлийн 1/3-ийг эзэлсэн үзүүлэлттэй гарсан. Өнгөрсөн онд томоохон улс орнуудын санхүүгийн хямралаас шалтгаалан гадаад зах зээл тогтвортгүй байсан, Монгол улсын гадаад худалдааны алдагдал их байснаас үүдэн дотоодын зах зээл дээрх ханшийн хөдөлгөөн их байсан зэрэг хүндрэлүүд арилжааны үйл ажиллагаанд эрсдэл учруулж байсан ч оновчтой бодлого хэрэгжүүлснээр банкийг ханшийн эрсдэлээс хамгаалж, валют арилжааны орлогыг нэмэгдүүлж чадлаа.


## Алтны арилжаа

2011 онд дотоодын алтны зах зээлийн хувьд Ашигт Малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж “Өсөн нэмэгдэх орлогын албан татвар”-ыг хэрэгжүүлж эхэлснээрээ онцлог жил боллоо. Энэхүү өөрчлөлтийг өөрийн хэрэглэж буй Грац программд амжилттай нэвтрүүлэн дахин сайжруулсан нь харилцагчдын талархалыг хүлээн алтны зах зээл дээр тэргүүлэх байр суурийг бататгаж өгсөн юм. Мөн харилцагч аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх тэдгээртэй нягт холбоотой ажиллаж санхүүгийн мэдээллээр хангах, алтны урьдчилгаат зээл, алт барьцаалсан бизнесийн зээл, банкны бусад үйлчилгээг ойртуулан ажиллаж байгаа нь ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажил болсон. Үүний илрэл нь өнгөрсөн онд харилцагч аж ахуйн нэгж, иргэдэд 9,434 тэрбум төгрөгийн алтны урьдчилгаат зээл олгож, 1,580 тонн биет алт худалдан авсан нь нийт дотоодын зах зээлийн 51%-ийг эзэлсэн явдал юм.


## Мөнгөний захын арилжаа

Мөнгөн хөрөнгийн удирдлагын гол зорилго нь харилцагчдын өмнө хүлээсэн төлбөр тооцооны үүргээ түргэн шуурхай гүйцэтгэхийн зэрэгцээ, банкны сул чөлөөтэй эх үүсвэрийг үр ашигтай байршуулах явдал байдаг билээ. Уг зорилтынхоо хүрээнд мөнгөний анхдагч болон хоёрдогч захын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, илүүдэл мөнгөн хөрөнгөө Төв банкны үнэт цаас, гадаад болон дотоодын нэр хүндтэй арилжааны банкуудын хадгаламж гэх мэт эрсдэл багатай, хүүгийн орлого олдог активуудад байршуулж ирсэн. Түүнчлэн Монгол улсын банк санхүүгийн зах зээлд тэргүүлэгчийн хувьд Засгийн газраас хэрэгжүүлж буй “4,000 орон сууц” хөтөлбөр, ноос ноолуурын салбар, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих гэх мэт томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх бондын арилжаанд идэвхтэй оролцож, төрөөс баримталж буй эдийн засгийг хөгжүүлэх бодлого зорилтуудыг дэмжин ажилласан. Тодруулбал өнгөрөгч онд нийт 75.8 тэрбум төгрөгийн бонд худалдаж авсан нь Засгийн газрын гаргасан нийт бондын 30%-ийг эзэлж байгаа бөгөөд багцын үлдэгдэл З дахин өсч, 100 тэрбумыг давсан нь ХХБ-ны дотоодын мөнгөний зах зээлд эзлэх байр суурийг илтгэсэн үзүүлэлт болж байна.


Валют арилжааны зах зээлд эзлэх хувь



Биет алтны зах зээлд эзлэх хувь



Мөнгөний зах зээлд эзлэх хувь



## Актив, пассивын удирдлага

ХХБ нь 2011 онд активын бүтцийг сайжруулж, хөрвөх чадвар болон ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, мөн шинээр эх үүсвэр татах замаар нийт активын хэмжээг өсгөх бодлого баримталж ажилласан. Үүний үр дүнд нийт активын хэмжээ 55.0 хувиар өсч, 2 их наяд төгрөгийг давлаа. Мөн активын бүтэц сайжирч, нийт активд эзлэх зээлийн хэмжээ 34.4 хувиас 53.9 хувь болж өссөн байна. Банк ашигт ажиллагаагаа нэмэгдүүлж, зээл олголтоо идэвхижүүлэхээс гадна хөрвөх чадвар өндөр, хүүгийн орлого олдог активуд болох Засгийн газрын бонд болон Төв банкны үнэт цаасны арилжаанд тогтмол идэвхтэй оролцсон байсан. Эх үүсвэр татан төвлөрүүлэх ажлын үр дүнд төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс татсан харилцах хадгаламж 39.8 хувиар, банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 265 хувиар тус тус өсч, банкны нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 55.1 хувиар нэмэгдэн, 1.9 их наяд төгрөгт хүрчээ. Үүний дотор бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууддаа урт хугацаатай, хүү багатай санхүүжилт олгох замаар бодит дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцохын зэрэгцээ гадаадын нэр хүндтэй банк, санхүүгийн байгууллагуудтай хийх хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, хамтын санхүүжилтын болон төслийн зээлийн эх үүсвэрийг 5.2 дахин өсгөсөн нь онцлох амжилтуудын нэг байлаа.



A photograph of a man and a woman in professional attire. The man, on the right, is wearing a dark suit, a light-colored shirt, and a blue striped tie. He is looking down at a document. The woman, on the left, has long dark hair and is wearing a light blue and white striped blouse. She is also looking down at the same document. They appear to be in an office setting. A large, stylized graphic element consisting of a grey triangle pointing right and a blue triangle nested within it is positioned on the left side of the image.

ЭРСДЭЛИЙН  
УДИРДЛАГА

# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

## Ерөнхий тойм

ХХБ нь Монголын банк санхүүгийн зах зээлд эрсдэлийн удирдлагыг чухалчлан, эрсдэлээс сэргийлэх үзэл санааг нэвтрүүлэн ажиллаж эхэлсэн анхны арилжааны банк ба 2003 онд анхны хараат бус эрсдэлийн удирдлагын газар, нэгжийг дотоод бүтцийн хүрээнд үүсгэн байгуулж ажиллаж эхэлсэн билээ. Бид банкны олон талт эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийн удирдлагын олон улсын арга, аргачлал, стандарт, жишгийг өөрийн банкны үйл ажиллагаанд нэвтрүүлэн, дотоодын банк санхүүгийн зах зээлд шинэ стандартыг бий болгох, эрсдэлээс сэргийлэх үзэл санааг хөгжүүлэх, банкны эрсдэлийн удирдлагыг сайжруулах чиглэлээр санаачлагч, шинэчлэгч, тэргүүлэгчийн байр суурийг хадгалан ажилладаг билээ.

Банкны эрсдэлийн удирдлагын бүтэц, тогтолцоо нь сайн засаглалын зарчим бүхий эрсдэлийн удирдлагын дэд бүтцийг хөгжүүлэх, банкны үндсэн төрлийн эрсдэлүүд болох зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, хөрөвөх чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл болон эрх зүйн хэрэгжилтийн эрсдэл гэсэн үндсэн эрсдэлүүдийг удирдахад чиглэдэг.

## Банкны эрсдэлийн удирдлагын дэд бүтэц, банкны засаглалын хөгжил

Тайлан хугацаанд банк нь сайн засаглалын зарчмын хүрээнд олон төрлийн шинэлэг ажлыг хийж гүйцэтгэсэн. Банкны эрсдэлийн удирдлагын түвшин, эрсдэлийн удирдлагын арга, аргачлал, засаглалын түвшинг үнэлэн дүгнэж тодорхой хугацааны давтамжтайгаар банкны Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнан ажиллах Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогчийн албан тушаалыг бий болгосон ба Эрсдэлийн удирдлагын хороог үүсгэн байгуулж, тус хороонд ажиллах бүрэлдэхүүн, хорооны ажиллах журмыг шинэчлэн баталсан. Хараат бус хяналтын тогтолцоог боловсронгуй, тодорхой болгон сайжруулсанаар сайн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэн ажиллах үндсэн суурь бүтэц бий болсон юм.

Банк нь сайн засаглалын зарчмуудыг хөгжүүлэх чиглэлээрх төлөвлөгөөг боловсруулан ажилладаг ба олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын нийтлэг жишгийн дагуу дараах үндсэн зарчмуудын дагуу стандартыг бий болгон анхааран ажиллаж байна. Үүнд:

- > Ажилтнуудын өрсөлдөх чадварыг сайжруулах;
- > Ажилтнуудын ажиллах нөхцөл, орчинг бүрдүүлэх;
- > Ажилтнуудыг мэргэжлийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт, хөтөлбөрийг тогтмол явуулах;
- > Урамшуулал цалингийн үр дүнтэй системийг нэвтрүүлэх;
- > Банкны эрсдэлийн удирдлага, хяналтын үйл ажиллагааг хараат бусаар хэрэгжүүлэх бүтцийг хөгжүүлэх;
- > Банкны эрсдэлийн аппетитыг банкны бүх бизнесийн нэгжүүд, хороод, гүйцэтгэх удирдлагууд мөрдөн ажиллах;
- > Банкны засаглалын түвшинг гадны байгууллагаар үнэлүүлэх, дүгнүүлж ажиллах;
- > Үүрэг хариуцлагын тодорхой байдал;
- > Нээлттэй ил тод байдал;
- > Ажилтнуудын шударга зарчимч байдал.

## Эрсдэлийн удирдлагын хороо, түүний үйл ажиллагаа, цар хүрээ

Банкны эрсдэлийн удирдлагын хороо нь банкны бизнесийн нэгжүүд, бусад хороодын мөрдөн ажиллах эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хамгийн дээд түвшин буюу эрсдэлийн аппетитыг тодорхойлон ажиллах ба эрсдэлийн удирдлагын арга аргачлалд үнэлэлт дүгнэлт өгөх, банкны засаглалын түвшин, хөгжлийг сайжруулах тал дээр анхааран, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг ханганд ажиллах дээд түвшиний бүтцийн нэгж юм. Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүнийг банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс ажлын туршлага, мэргэжлийн ур чадварыг үндэслэн тогтоож, сонгон ажиллуулдаг ба хорооны бүрэлдэхүүнд хараат бус гишүүнийг томилон ажиллуулдаг.

Тайлант хугацаанд, банк нь нийгэм эдийн засаг, хууль эрх зүй, хүрээлэн буй орчны зүгээс банкны үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг урьдчилан таамаглан амжилттай удирдан ажилласан ба хөрвөх чадварын эрсдэл, зах зээлийн эрсдэл, зээлийн эрсдэл болон үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг Эрсдэлийн удирдлагын хорооноос батлагдсан эрсдэлийн аппетит, холбогдох лимитийн хүрээнд оновчтой хэрэгжүүлэн ажиллалаа. Эрсдэлийн удирдлагын хорооны дарга нь банкны учирч болох эрсдэлийн түвшин, чиг хандлага, мөн эрсдэлийн удирдлагын хорооны хурлаар хэлэлцэх сэдвүүдийн талаар банкны Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч болон, Ерөнхий аудитортой тогтмол хэлэлцэн ажилласан.

Банкны эрсдэлийн удирдлагын хороо нь дараах төрлийн ажил үүргийг хэлэлцэн ажиллалаа. Үүнд:

- > Банкны хувь нийлүүлэгчидийн эрх ашгийг хамгаалах төлөвлөгөөт ажлын хүрээнд Банкны хүлээж болох эрсдэлийн түвшин буюу эрсдэлийн аппетитийн түвшинг тогтоох, батлах;
- > Банкны эрсдэлийн аппетитийн биелэлтийг хянах, зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд баримтлах лимитийг эзслэн тогтоох, батлах;
- > Банкны эрсдэлийн удирдлагын чиг хандлага, хөгжлийн түвшинг үнэлэх, хянах;
- > Банкны гүйцэтгэх удирдлага, бизнесийн нэгжүүд нь эрсдэлийг тогтоон, хангалттай түвшинд удирдан ажиллаж байгаа эсэхийг хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх;
- > Банкны үйл ажиллагаанд эрсдэлээс сэргийлэх соёл, үзэл бодлыг нэвтрүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллах;
- > Банкны компанийн засаглалын түвшин, засаглалын үндсэн зарчмуудын хөгжилд үнэлэлт дүгнэлт өгөх, сайн засаглалын үндсэн зарчмуудыг хөгжүүлэх чиглэлээр хөтөлбөр гаргах, биелэлтийг дүгнэх.

Банкны эрсдэлийн удирдлагын газар нь Эрсдэлийн удирдлагын хорооноос гаргасан шийдвэрийн дагуу эрсдэлийн аппетит, лимитийн биелэлтийг хянан, тайлагнан ажилладаг.

## Стратгийн эрсдэлийн удирдлага

Банк нь макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, ажилгүйдэл, инфляци, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт бууралт, эдийн засгийн мөчлөгүүдийн хэтийн төлөв, өөрчлөлтөөс учирч болох эрсдэлийн түвшинг үнэлэн дүгнэж, эрсдэлийг бууруулах чиглэлээр хариу арга хэмжээг төлөвлөн ажилладаг. 2011 онд эдийн засгийн голлох салбарууд болох уул уурхай, барилга, аж үйлдвэрийн салбарт баримтлах бодлогыг тухай салбарын хэтийн төлөв, үндсэн үзүүлэлтийн өсөлт бууралт, хууль эрх зүйн орчин, нөхцөл засгийн газрын зүгээс баримтлах бодлого зэрэгт үндэслэн учирч болох эрсдэлийн түвшинг тодорхойлон, эрсдэлийг бууруулан удирдах хариу арга хэмжээг төлөвлөн эрсдэлийн удирдлагыг ханганд ажиллалаа.

Тайлант хугацаанд, банк нь цэвэр хүүгийн маржин, ашгийн хувь хэмжээг зах зээлийн өрсөлдөөнт нөхцөлд зорилтот түвшинд хадгалан, пассив хөрөнгийн бүтцийг хүүгийн зардал бага эх үүсвэрээр төрөлжүүлэн тогтоож, пассив хөрөнгийн жигнэсэн дундаж хүүгийн зардалыг бууруулан хүүгийн эрсдэлийн удирдлагыг ханганд ажиллалаа.

Банкны зээлийн бүтээгдэхүүнийг жижиг бизнесийн зах зээл, иргэдэд илүүтэй борлуулан зээлийн жигнэсэн

дундаж хүүгийн хувь хэмжээг тогтвортой түвшинд хадгалахыг зорин ажилласан билээ. Энэхүү хүүгийн эрсдэлийн удирдлага, актив болон пассив хөрөнгийн оновчтой багц сонголтын үйл явцын үр дүнд банкны хүүгийн цэвэр ашгийн түвшин, хувь хэмжээ зорилтот түвшинд хадгалагдан, ашигт ажиллагааг ханган хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг амжилттайгаар өсгөн ажиллахад өөрийн үүргээ гүйцэтгэсэн.

Банкны зээлийн бүтээгдэхүүний борлуулалтанд тавих шалгуур үзүүлэлтийг хууль эрх зүйн орчин, эдийн засгийн мөчлөг, эрэлт, нийлүүлэлтийн түвшин, банкны салбарын өрсөлдөөнийн түвшинд нийцүүлэн, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагат байдалд нийцүүлэн тогтоохын зэрэгцээ банкинд учирч болох эрсдэлийг бууруулах чиглэлээр илүүтэй анхааран ажиллалаа.


Түүнчлэн ХХБ-ны хувьд инфляцийн өсөлт, түүнээс үүдэн бий болж болзошгүй сөрөг үр дагавар, эрсдэлийг удирдах хариу арга хэмжээ төлөвлөн ажилласан ба үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг эдийн засгийн нарийн судалгаа тооцооллын үндсэн дээр бодит байдалд нийцүүлэн тогтоох замаар барилгын салбарын хэт үнийн өсөлтөөс учирч болох эрсдэлийг амжилттай удирдан ажиллалаа. Банк нь өргөн хэрэглээний бараа, шатахууны үнийн өсөлтийг тодорхой хугацааны мөчлөгөөр таамаглан ажилласан ба зээлдэгчдийн бизнесийн бодит өсөлтөд тулгуурлан, зээлийн санхүүжилтийн түвшинг тогтоох замаар бодит хэрэгцээг үнэлэн тооцоолон эрсдэлийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

2012 онд эдийн засаг, улс төрийн онцлог, төлөв, байдлаас хамааран өргөн хэрэглээний бараа, үл хөдлөх хөрөнгийн үнэ ихээр өсөх дүр зураг байгаа тул банк зээлийн барьцаа хөрөнгийн чанарыг сайжруулах, зээлийн судалгааны шалгуур үзүүлэлтээ өсгөх, зээлдэгчдийн бизнесийн өсөлтийг бодит өсөлт талаас нь илүүтэй шинжлэн шийдвэр гаргаж ажиллах замаар эрсдэлийн удирдлагыг ханган ажиллана. Мөн эдийн засгийн голлох салбаруудад олгох зээлийн багцын түвшинд тогтоох лимитийг эдийн засгийн мөчлөг, өсөлттэй уялдуулан тогтоох замаар эрсдэлийн удирдлагыг хангаж ажиллана.

## Капиталын удирдлага


2011 онд ХХБ нь Монгол банкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан ба хамаарах эрсдэлээр жигнэсэн актив хөрөнгийн бүтцийг оновчтой тодорхойлон эрсдэлийн удирдлагыг ханган ажиллалаа. Тайлант хугацаанд өөрийн хөрөнгийн шаардлага нь: 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 6%-аас багагүй, нийт өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 12%-аас багагүй байхаар тогтоосон байв.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт (2009-2011)



ХХБ нь Олон улсын Basel II зарчмын тулгуур ойлголтууд, зарчмуудыг банкны өөрийн нөөц бололцооны хүрээнд дотоод үйл ажиллагаанд тооцон эрсдэлийн удирдлагыг хангах ажлыг эхлүүлсэн ба зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл болон үйл ажиллагааны эрсдэлийн учирч болзошгүй эрсдэл, алдагдалын түвшинд эдийн засгийн капиталын түвшинг тооцон, капиталын нөөц хөрөнгийг тусгаарлан байгуулж, эрсдэл, алдагдалаас хамгаалан ажиллахад чиглэсэн судалгаат ажлыг эхлүүлэн ажиллаж байна. Банкны эрсдэлийн удирдлага, хяналтын үйл ажиллагаа нь дараах дэд бүтцийн хүрээнд хэрэгждэг.

## Эрсдэлийн удирдлагын засаглалын бүтэц



# БАНКНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

### Зээлийн бодлого

ХХБ нь эдийн засгийн хүчин зүйл, орчин, мөчилөг, мөнгө санхүүгийн зах зээлтэй уялдуулан, олон улсын Baselyn хорооноос гаргасан зарчмуудын дагуу банкны мөрдөн ажиллах зээлийн бодлогыг боловсруулдаг. Тайлант хугацаанд банкны зээлийн бодлого нь зээлийн багцын түвшинг эрсдэлийн удирдлагын сайн тогтолцооны хүрээнд өсгөн нэмэгдүүлэхэд чиглэж байсан тул зээлийн багцын түвшин төлөвлөсөн тувшинд хүрч, өсөн нэмэгдсэн ба зээлийн чанаргүй зээлийн дүн хэмжээ, нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь буурсан үзүүлэлттэй байгаа нь тайлант онд хэрэгжүүлсэн банкны зээлийн эрсдэлийн удирдлагын бодлого үр дүнтэй байсныг харуулж байгаа юм. Зээлийн бодлогын хүрээнд банкны найдвартай сайн харилцагчдын бизнесийн үйл ажиллагааг дэмжих, шинэ зээлдэгчид, харилцагчдын хамтын ажиллагааг эхлүүлэх, өрнүүлэх, бэхжүүлэх төлөвлөгөөг боловсруулан ажиллахын зэрэгцээ зээлдэгчдэд тавих шалгуур үзүүлэлтэй эрсдэлийн хүчин зүйл, эрсдэлийн түвшингээс нь хамааран тогтоож, багцын өсөлтийг хангтан ажилласан нь зээлийн багцын чанарт сайнаар нөлөөлсөн.

### Зээлийн судалгаа

ХХБ нь зээлийн судалгаа, зээлдэгчдэд тавих шалгуур үзүүлэлтийг үнэлэн дүгнэх ажлын хүрээнд зээлдэгчийн зээлжих эрсдэлийн үнэлэмжийг олон улсын Baselийн хорооноос тогтоосон шаардлагын дагуу дотоод үнэлгээний модуль ашиглан тогтоо ажлыг 2005 оноос эхэлсэн ба энэхүү үйл ажиллагаа нь Монголын банкны системд анхдагч болж ирсэн юм.

ХХБ нь зээлийн санал, хүсэлтийг хурдан шуурхай шийдвэрлэн ажиллахыг чухалчлан үзэхийн зэрэгцээ эрсдэлийн үнэлэмж, тоон болон чанарын хүчин зүйлийн үнэлгээг зээлдэгчийн санхүүгийн хүчин чадал, боломж, барьцаа хөрөнгийн хүрэлцээг судлан үзсний үндсэн дээр зээлийн олгох дүнгийн хэмжээ, зээлийн хүү, хугацааг тогтоон ажилладаг ба зээлдэгчдийн бизнесийн үйл ажиллагааг үр дүнтэй явагдах үйл явцад анхааран, санхүүгийн удирдлага, эрсдэлийн удирдлагын талаар зөвлөмж өгч, хамтын ажиллагааг бэхжүүлэн ажилладаг.

### Зээлийн шийдвэр гаргалт

Зээлийн санал, хүсэлт нь банкны зээлийн хороодын хурааар хэлэлцүүлэгдэн шийдвэрлэгддэг ба корпорацийн засаглалын үндсэн зарчмын хүрээнд эрсдэлийн удирдлагын хараат бус төлөөлөл хурлын бүрэлдэхүүнд орж шийдвэрлэх үргийг гүйцэтгэн ажилладаг.

### Зээл олгосны дараах хяналт, эрсдэлтэй зээлийн удирдлага

ХХБ нь зээлийн олголтын дараах хяналтыг зээлдэгчийн эрсдэлийн түвшин, бизнесийн онцлог, туршлага зэргээс хамааран тодорхой хугацааны давтамжтайгаар хийдэг ба энэхүү үйл ажиллагаа нь зээлийн багцын чанарыг зохистой түвшинд хадгалах үндсэн суурь болдог онцлогтой.

Зээлийн олгосны дараах эргэн хяналтыг зээлийн хороодын хурааар зээлийн эрсдэлийн түвшинг хэлэлцэн тодорхойлох замаар гүйцэтгэдэг ба зээлээс хүлээж болзошгүй эрсдэл нь хүлээн зөвшөөрөгдсөн түвшингээс хэтэрсэн тохиолдолд банк зээлийн эргэн төлөлтийг хангахад чиглэсэн цогц төлөвлөгөөг боловсруулан учирч болзошгүй эрсдэлийг бууруулан ажилладаг ба энэ нь зээлдэгчийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах замаар бизнесийн үйл ажиллагааг дэмжин ажиллах нэг хэлбэр юм. Зээлийн эргэн төлөлтийн үйл ажиллагаанд хундрэл учирсан, улмаар эргэн төлөх боломж муудсан нөхцөлд банк Монгол банкны Ерөнхийлөгч болон болон Сангийн яамны сайдын тушаалаар батлагдсан "Актив хөрөнгийг ангилах, сан байгуулах" журмын хүрээнд зээлийн ангиллыг бууруулан ажилладаг ба эрсдэлийн түвшингээс хамааруулан зээлийг төлүүлэх цогц арга хэмжээг төлөвлөн, эрсдэлийн удирдлагыг хангаж ажилладаг.

Банк нь чанаргүй, эрсдэлтэй зээлийн эргэн төлөлтийг хангуулах чиглэлээр олон талт арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг ба тайлант оны эхнээс чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувийг бууруулах зорилт тавин, олон талт арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд 2010 оны эцэст хугацаа хэтэрсэн

зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 3.53 хувь, чанаргүй зээлийн хувь 4.12 хувь байсан бол 2011 оны эцсийн байдлаар хугацаа хэтэрсэн зээл нийт зээлийн багцын 0.52 хувь, чанаргүй зээл 2.47 хувь болж тус тус буурсан байна.

2011 оны 12 сарын 31-ний байдлаар хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн дүн 2010 оны 12 сарын 31-тэй харьцуулахад нийтдээ 6.97 хувиар буурсан нь тайлант хугацаанд банкны зээлийн олгосны дараах хяналт үр дүнтэй, эрсдэлтэй зээлийн эрсдэлийн удирдлага сайн байгааг харуулж байна. Тайлант хугацаан дахь зээлийн багцын чанарыг харуулбал:

## **Барьцаа хөрөнгийн эрсдэлийн удирдлага**

Банк нь зээлийн барьцаанд авах барьцаа хөрөнгийн төрөл, шалгуур үзүүлэлт, барьцаа хөрөнгийн үнэлгээний зарчим, арга аргачлал, барьцаа хөрөнгийн зүгээс банкинд учирч болох эрсдэлийг бууруулах үүднээс барьцаа хөрөнгийн бодлогыг боловсруулан ажилладаг. Банк нь зээлдэгчийн зээл эргүүлэн төлөх бодит орлого, бизнесийн бодит орлогын зээлийг төлөх чадамжид тулгуурлан зээлийн барьцаанд тавих хөрөнгийн агуулга, төрлийг тодорхойлдог ба тайлант оны эцсээр банкны нийт зээлийн багцын барьцаа хөрөнгийн цэвэр үнэлгээгээр нөхөх хувийн жин хангалттай түвшинд буюу 185 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Банкны барьцаа хөрөнгийн үнэлгээг Эрсдэлийн удирдлагын газрын барьцаа хөрөнгийн шинжээч хараат бусаар, бие даан үнэлэн тогтоох ба зах зээлийн, зардалын болон орлогын хандлагын аргаар үнэлэн харьцуулан жишиг замаар эцсийн үнэлгээг бодит байдалд илүү нийцүүлэн тогтоодог.

## **Зээлийн багцын эрсдэлийн удирдлага**

ХХБ нь зээлийн багц, түүнээс алдаж болох алдагдалын хэмжээг математик магадлал, статистикийн аргаар үнэлэн дүгнэж, учир болох алдагдалын дүнг тооцоолон, эрсдэлийн удирдлагыг хангаж ажилладаг. Тайлант хугацаанд банк нь Олон улсын Базелийн хорооноос гаргасан Базел II зарчмын дагуу зээлдэгчийн зээлийн алдагдалыг өнгөрсөн хугацааны түүхэн мэдээлэл, судалгаан дээр үндэслэн тооцоолох (PD), мөн зээлийн эргэн төлөгдөхгүй дүн хэмжээг тодорхойлох (LGD) аргачлалыг нэвтрүүлэн ажиллаж эхэлсэн нь зээлийн эрсдэлийг тодорхойлон, үнэлэх арга аргачлалд гарсан томоохон дэвшилт юм. Тус арга аргачлалыг нэвтрүүлснээр зээлдэгчийн хүлээж болзошгүй алдагдал, түүний хамаарал (correlation), тооцоог түйцэтгэн эдийн засгийн салбаруудад олгох зээлийн нийт багцын дүн хэмжээнд лимит тогтоох бүрэн боломжтой болсон билээ.

Мөн банкны бодлогын хүрээнд нэг эдийн засгийн салбарт олгох зээлийн нийт дүнгийн хэмжээг нийт зээлийн багцын тодорхой хувиас хэтрүүлэхгүй түвшинд барих бодлого барин ажилладаг.

## **Стресс тест, сценари анализ**

Банк нь зээлийн багцын орох мөнгөн урсгалын түвшинг өнгөрсөн түүхэн хугацааны мэдээлэлд үндэслэн хамгийн муу тохиолдлын стрес тест, олон нөхцөлт хувилбар буюу сценари гарган тодорхойлон шинжилдэг ба тухайн тохиолдол тус бүрд банкны бизнес үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн түвшинг тодорхойлон, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг төлөвлөн эрсдэлийн удирдлагыг хангаж ажилладаг.

## Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Уг тайлант хугацаанд, ХХБ нь Монголбанк болон Базелийн хорооны шаардлагууд, олон улсын практик зөвлөмжүүд дээр үндэслэн хөрвөх чадварын эрсдэлийг удирдах арга, аргачлалыг шинэчлэн сайжруулсан. Үндсэн өөрчлөлт нь банкны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх цогц үйл явц буюу эрсдэлийг тогтоох, үнэлэх, хэмжих, тайлагнах, эрсдэлийг бууруулах санал дүгнэлт гаргах болон эргэн хяналттай холбогдон үүсэх харилцааг илүү тодорхой зохицуулахад чиглэсэн.

Банк нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хүрээнд Монголбанкны журмын дагуу заавал байлгах нөөцийг хангалттай түвшинд ханган байршуулж, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай активын зохистой харьцааг тогтмол биелүүлэн, банкны ирээдүйд орох, гарах мөнгөн урсгалыг "Gap" аргачлал, тооцооллын дагуу хөрвөх чадварын шинжилгээг хийн, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилладаг. Ерөнхийдөө, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Эрсдэлийн удирдлагын хорооноос тодорхойлсон эрсдэлийн аппетитийн дагуу пассив хөрөнгийн бүтэц, нөхцлийг оновчтой тодорхойлоход чиглэдэг.

Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах үндсэн нөхцлүүд. Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах 3 түвшин бүхий нөхцөл байдалд дун шинжилгээг хийж, эрсдэлийн удирдлагыг ханганд ажилладаг.

- > Хэвийн нөхцөл байдал: Зах зээлийн нөхцөл байдал хэвийн, банкны тогтоосон хөрвөх чадварын харьцаа болон бусад шалгуур үзүүлэлтүүд лимитийн хүрээнд хангагдан байгаа нөхцөл;
- > Хэвийн бус нөхцөл байдал: Зах зээлийн нөхцөл байдал хэвийн, банкны тогтоосон хөрвөх чадварын харьцаа болон бусад шалгуур үзүүлэлтүүд лимитийн хүрээнээс хэтэрсэн, балансын бүтэц хэвийн нөхцөл;
- > Хүндрэлийн үеийн нөхцөл байдал: Зах зээлийн нөхцөл байдал тогтвортгуй, банкны тогтоосон хөрвөх чадварын харьцаа болон бусад шалгуур үзүүлэлтүүд лимитийн хүрээнээс хэтэрсэн бөгөөд тухайн байдал нь банкны хөрвөх чадварт хүндрэл учруулахаар, бизнес үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл.

Тайлант хугацаанд ХХБ нь хөрвөх чадварын эрсдэлийг хэвийн нөхцөл байдлын түвшинд удирдан, актив, пассив хөрөнгийн удирдлагыг гүйцэтгэн ажилласан.

## Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын лимит


ХХБ нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд баримтлах Монгол банкны шаардлага, харьцаанаас гадна олон улсын стандарт шаардлагын дагуу банкны хөрвөх чадварыг илэрхийлэн хэмжих дараах 4 бүлэг харьцаануудад лимит тогтоон, биелэлтийг ханганд ажиллалаа.

### Балансын төлбөрийн чадварын үзүүлэлт

ХХБ нь Олон улсын үнэлгээний байгууллага "Moody's"-ийн стандарт, шаардлагын дагуу хөрвөх чадварын харьцааг хангаж ажилладаг. Тус шаардлагын дагуу хөрвөх чадварын эрсдэлийг удирдан, актив, пассив хөрөнгийн зохистой бүтцийг хадгалж улмаар ажилладаг. Энэ нь ХХБ олон улсын үнэлгээний байгууллага, хөрөнгө оруулагчдын стандарт шаардлагыг ханганд ажиллаж байгааг нотолсон үзүүлэлт юм.

### Хөрөнгө ба эх үүсвэрийн зохистой харьцааны үзүүлэлт

ХХБ нь харилцагчийн хүсэлтийг цаг хугацаанд биелүүлэх, мөнгөн хөрөнгийн гарах урсгалыг ханганд ажиллахтай холбоотойгоор богино хугацааны үечлэлд мөнгөн хөрөнгийн орох урсгалыг гарах урсгалаас их байлгах хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын суурь зарчмын хүрээнд шаардлагатай харьцааг



тогтоон, мөрдөн ажилладаг. Нөгөө талаас мөн урт хугацааны үечлэлүүдийн мөнгөн хөрөнгийн орох болон гарах урсгалын түвшинд зохистой харьцааг барьж ажиллан хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг ханган ажилладаг.

## GAP аргачлалын дагуу тооцох мөнгөн урсгалын тайлан

ХХБ нь ирээдүйн тодорхой хугацаан дахь орох, гарах мөнгөн урсгалын зөрүүг шинжилэн, шаардлагатай хөрвөх чадвартай хөрөнгийн түвшинг тодорхойлон ажилладаг ба цэвэр мөнгөн урсгалын зөрүү болон хуримтлагдсан мөнгөн урсгалын түвшинд лимит тогтоон хөрвөх чадварын эрсдэлийг удирддаг.

## Эх үүсвэрийн төвлөрлийн үзүүлэлт

ХХБ нь эх үүсвэрийн төвлөрлийн түвшинг бууруулах үүднээс эх үүсвэрийн бүтцийн түвшинд лимит тогтоон, зохистой түвшинд мөрдөн ажилладаг. Түүнчлэн эх үүсвэрийг бусад төрлийн эх үүсвэрээр төрөлжүүлэн ажилладаг ба дотоодын өрсөлдөгч санхүүгийн байгууллага дундаас анх удаа олон улсын зах зээлд урт хугацаат бондыг амжилттайгаар гарган эх үүсвэрийн төрөлжүүлэлийг ханган ажилласан.

## Хөрвөх чадварын стресс тест

Гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн банк хөрвөх чадварын эрсдэл хүлээх гэнэтийн тохиолдол хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор стресс тест, сценари шинжилгээг хийж, учирч болох эрсдэлийг удирдах арга, замыг тодорхойлон ажиллаж байна. Зах зээлийн онцгой нөхцөл байдал буюу стресс тестийг тодорхойлон, тус нөхцөл байдлыг даван туулах нөөц хөрөнгийн түвшин, чадамжийг тооцоолон, боломжит хувилбар, арга, аргачлалыг агуулсан төлөвлөгөөг гарган ажилладаг. Энэ бүхний туслалцаатайгаар банк нь олон хувилбарт тохиолдлын шинжилгээ /сценари/, стресс тест, хөрвөх чадварын эрсдэлийг удирдах чадамжид үндэслэн ирээдүйд хөрвөх чадвар эрсдэлд орж болзошгүй сигнал, муу тохиолдолыг урьдчилан тогтоон, бэлтгэн ажлыг ханган ажиллаж байна.

## Хөрвөх чадварын хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Тайлант хугацаанд ХХБ нь хөрвөх чадварын хүндрэлийн үеийн төлөвлөгөөг олон улсын стандарт байдалд нийцүүлэн сайжруулсан. Энэхүү төлөвлөгөөний зорилго нь банкны хөрвөх чадварт эрсдэл учирч болзошгүй буюу хүндрэл үүсэх нөхцөл байдлыг урьдчилан тодорхойлон, тус нөхцөл байдлыг амжилттайгаар удирдах арга, аргачлалыг тусгахад чиглэдэг.

Нийт эх үүсвэрийн 79% нь тогтвортой эх үүсвэр байгаа бөгөөд энэ нь эх үүсвэрийн бүтцээс хамааран учирч болох хөрвөх чадварын эрсдэл бага байгааг илэрхийлэх төдийгүй урт хугацаанд актив хөрөнгийг санхүүжүүлэх чадамж өндөр байгааг харуулж байна.

Эх үүсвэрийн төлөв



## Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Зах зээлийн эрсдэл гэж банк зах зээлийн онцлог түвшин, нөхцөлд санхүүгийн позицийн удирдлагыг хэрэгжүүлэн, эрсдэлээс хамгаалан ажиллаагүйгээс алдагдал хүлээх эрсдэлийг хэлдэг. Банк нь хүүгийн түвшин, коммодоти барааны үнэ болон валютын ханшны өөрчлөлтөөс эрсдэлд өртөж болно.

## Хүүгийн эрсдэлийн удирдлага

ХХБ нь суурь хүүгийн түвшин болон цэвэр хүүгийн ахиуцад зах зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтөөс учирч болох нөлөөллийг шинжлэн дүгнэж хүүгийн эрсдэлийг удирдан ажилладаг.

Тайлант хугацаанд, банкны суурь хүүгийн тогтолцоог илүү нарийвчлан тооцох арга аргачлал, бүтцийг бий болгон суурь хүүгийн түвшинд хамаарах зээлийн эрсдэлийн хувь хэмжээний судалгааг эрсдэлийн түвшингээс хамааруулан тогтоож ажилласан ба хүүгийн өөрчлөлтийн мэдрэмжийн шинжилгээг хийх боломжит хувилбарыг гаргасан. Энэ аргачлалыг бүрэн хэрэгжүүлснээр хүүгийн мэдрэмжтэй актив, пассив хөрөнгийн хүүгийн хувь хэмжээний ирээдүйн өөрчлөгдж болох хэмжээ болон магадлалыг цаг хугацааны мөчлөгөөр тооцон, актив болон пассив хөрөнгийн хүүгийн хувь хэмжээнээс үүдэн гарах ашиг алдагдлыг урьдчилан тооцох боломжтой болох юм.

Цаашлаад хүүгийн стресс тест болон тохиолдлын шинжилгээ хийх боломжтой болсон.

## Валютын ханшийн эрсдэлийн удирдлага

Тайлант онд ХХБ нь гадаад валютын ханшийн эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

### Гадаад валютын багцын эрсдэл

ХХБ нь арилжааны багцаас хүлээж болзошгүй алдагдлыг VaR арга (Value at Risk)-ыг ашиглан тооцоолох зөвшөөрлийг Монголбанкнаас авсан анхдагч банк бөгөөд уг аргаар 2003 оноос хойш гадаад валютын багцын эрсдэлийг хэмжин, удирдаж байна. Уг аргачлалаар хэмжин гаргасан эрсдэлийн түвшин нь банкны Эрсдэлийн удирдлагын хорооноос батлагдсан хязгааруудын хүрээнд байгаа эсэхэд ажлын өдөр бүр хяналт тавьж ажилладаг. ХХБ нь гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас нийт багцаас хүлээж болзошгүй алдагдлын хэмжээг тооцоходоо Монголбанкнаас санал болгосон аргачлалын хүрээнд EWMA, EGARCH, Monte Carlo simulation, Historical simulation гэсэн аргуудыг хослуулан ашигладаг бөгөөд энэ нь багцаас хүлээж болох алдагдлыг бодитой тооцох, багцыг оновчтой удирдах бүрэн боломжийг олгож байгаа юм.

### Тайлант хугацааны VaR утгын буцаан шалгалт

Банкны арилжааны багцаас алдаж болох алдагдлыг бодитойгоор үнэлж буй эсэхийг тогтоохдоо буцаан шалгалтын /backtesting/ аргыг хэрэглэдэг бөгөөд үүний үр дүнд VaR хязгаарлалтаас илүү гарсан алдагдлын тоо нь итгэлцлийн түвшинд харгалзах зөвшөөрөгдхөх хэмжээнд буюу Монголбанкны шалгуурт нийцэж байгаа эсэхэд өдөр бүр хяналт тавьж ажилладаг. Тайлант хугацаанд, буцаан шалгалтын үр дүн нь Монголбанкны шалгууруын ногоон бүсэд байлаа.

Ногоон бүс (Ажиглалтын утга зөрсөн тоо 0-4): Загварыг үнэн зөв тооцож байна гэж үзнэ.

Буцаан шалгалт (250 хоног)	Монголбанкны шалгуур	
	Хэтэрсэн утга	Бүс
VaR утга (итгэлцлийн түвшин 99%)	2	Ногоон

## Стресс сценари шинжилгээ

Багцаас хүлээж болзошгүй алдагдлыг тооцохоос гадна гэнэтийн хүчтэй хэлбэлзэл тохиолдох магадлал, хүчтэй хэлбэлзэл гарахад үүсч болох алдагдал зэргийг Монголбанкны зөвлөмжид санал болгосон экстрем хэлбэрийн тархалтаар эрсдэлийг тооцох аргыг ашиглан тооцоолдог. Ийнхүү тооцсон гэнэтийн хүчтэй хэлбэлзлээс хүлээж болзошгүй алдагдлын хэмжээг банкны гүйцэтгэх удирдлагууд болон хөрөнгийн удирдлага, санхүүгийн удирдлагын газар нэгжүүдэд тогтмол мэдээллэн учирч болох эрсдэлийг удирдан ажиллаж байна.

## Бүс нутгийн эрсдэл, түүний удирдлага

ХХБ нь гадаад болон дотоодын зах зээл, түүний онцлог чанар, улс орны хөгжлийн түвшингээс хамааруулан, тус бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа харилцагч банкуудтай хамтран ажиллах цар хүрээ, арилжааны төрөл бүрийн лимит, харьцааг тогтоон ажилладаг. Тайлант хугацаанд, эдгээр харилцагч байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэн, төрөлжүүлэх, цар хүрээг тэлэхэд чиглэн ажилласан ба түүнтэй холбоотой учирч болох эрсдэлийн түвшинг үнэлэн дүгнэн ажилласан билээ.

## Нэр хүндийн эрсдэл, түүний удирдлага

ХХБ-ны нийт ажилтнууд, албан хаагчид нь эрсдэлийн удирдлагыг ханган ажиллах нэгдсэн бодлого, Захиргаа хүний нөөцийн газраас тогтоодог ёс зүйн дүрэм, шаардлагыг баримтлан харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хүндэтгэн ажиллах ба энэ бүх үйл ажиллагаа банкны нэр хүндийн эрсдэлийг бууруулах үйл явцыг дэмжих хүчин зүйл болдог. Банкны нийт албан хаагчид, ажилтнуудад банкны ажилтны заавал мөрдөн ажиллах ёс зүйн дүрэм, түүний мөн чанарын талаар тогтмол сургалт, хэлэлцүүлэг хийж ажилласан ба банкны онцлог чанар, дотоод соёл, эрхэм чанарыг ойлгон дээдэлж, нэр хүндийг сахин хамгаалах тал дээр тайлант хугацаанд анхааран ажилласан.

## 2012 онд эрсдэлийн удирдлагын арга, аргачлал түүний чиглэлээр хийгдэх ажлууд

Тус хугацаанд, банк нь эрсдэлийн удирдлагын арга аргачлалын талаар олон улсын туршлагаас суралцах, эрсдэлийн шинжээчид, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг олон улсын жишигт хүргэн дээшлүүлэх, сайн засаглалын зарчмууд, түүний ач холбогдлыг үнэлэн дүгнэж, банкны засаглалыг олон улсын жишигт хүргэхэд чиглэсэн бүрэн хэмжээний төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллах ба энэхүү ажлын хүрээнд Олон улсын мэргэшсэн холбоодтой хамтран ажиллах, туршлагаас суралцах тал дээр түлхүү анхаарах юм.





МЭДЭЭЛЛИЙН  
ТЕХНОЛОГИ

# МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

ХХБанк нь мэдээллийн технологийн дэд бүтцийн өргөтгөл, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг онцгой анхааран, хөрөнгө оруулалт, хөгжүүлэлтүүдийг тогтмол хийж ажилладаг.

2011 онд ХХБанкны бизнесийн үйл ажиллагаа улам өргөжин тэлж салбар, тооцооны төв 18-аар, ATM терминалын тоо 20-оор нэмэгдсэн болон бусад хамтран ажиллагч байгууллагуудтай онлайн холболт хийгдэж, мэдээллийн технологийн дэд бүтцийн өргөтгөлийн ажлууд хийгдлээ.

Банкны нөөцийн төвийг шилжүүлэн, өндөр хүчин чадал бүхий сервер систем болон өндөр хурдны шилэн кабелийн холболттойгоор шинэчлэн зохион байгууллаа. Мөн технологийн шинэчлэл хийж, мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасны зэрэгцээ мэдээллийн сангхугацааны ямарч зөрүүгүйгээр нөөцийн төв рүү онлайн байдлаар шууд дамжуулж байна.

Тайлант онд мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хангах, олон улсын стандартыг нэвтрүүлж ажиллах талаар хэд хэдэн томоохон ажлууд хийгдсэн. Тухайлбал: Олон улсын мэдээллийн аюулгүй байдлын стандартыг хангах аудитыг хийлгэн, холбогдох арга хэмжээг авч ажилласны зэрэгцээ мэдээллийн аюулгүй байдлын тоног төхөөрөмжийг сайжруулан шинэчиллээ.





ХҮНИЙ  
НӨӨШИЙН  
УДИРДЛАГА

# ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

2011 он ХХБ-ны хувьд үйл ажиллагаа, үйлчилгээний цар хүрээ өндөр хурдацтай өргөжин тэлсэн жил байсан учир хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа, зохион байгуулалт банкны эрхэм зорилгыг хэрэгжүүлэн энэхүү өсөлтийг хангаж чадахуйц хүний нөөцийн тоо болон чанарын өсөлтийг бий болгоход чиглэгдэж байв.

Тайлант хугацаанд банкны хүний нөөцийн үйл ажиллагаа дараах үндсэн хэсгүүдэд чиглэгдэв. Үүнд:


- > Хүний нөөцийн төлөвлөлт, хангарт, хөгжлийн асуудлыг банкны стратегийн бодлого, бизнес төлөвлөгөөтэй уялдуулан банкны үйл ажиллагаа, цар хүрээ, одоо байгаа болон шинээр нэвтрүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг хийж гүйцэтгэх чадварлаг мэргэшсэн ажилтнуудыг тогтвортой ажиллуулах, сургах, тэднийг идэвхижүүлэх, Зөв бөгөөд Хэрэгтэй хумуссээр хамт олны эгнээг өргөтгөх; 2010 онтой харьцуулахад ажилтнуудын тоо 25.9 хувиар, шинээр томилогдон ажиллаж буй ажилтнуудын тоо 68.6 хувиар тус тус өсөж нийт ажилчдын тоо 1000-д хүрэв.
- > Ажилтны ёс зүй, идэвхи, бүтээмж, банкны хөгжил болон бизнест оруулж буй хувь хэмжээнд тулгуурласан урамшууллын систем болон ажилтны ажлын гүйцэтгэлд бодит үнэлгээ өгөх тогтолцоог боловсронгуй болгох;
- > Ажилтан бүр банкны үнэт зүйл гэдгээ ойлгож, түүгээрээ бахархдаг сэтгэл зүйг улам батжуулах, байгууллагын соёлыг банкны үнэт зүйл болох ажилтан бүрийн соёлын түвшинг нэмэгдүүлэх замаар сайжруулах;

Худалдаа хөгжлийн банк дотоод, гадаад эх үүсвэрийн аль алинаас сонголт хийдэг тогтворжсон системтэй бөгөөд банкны хүний нөөцийн бодлогын гол чиглэл нь аль болох дотоод эх үүсвэрээ ашиглах, үүний тулд одоо ажиллаж байгаа ажилтнуудаа хөгжүүлэх, мэргэшүүлэх замаар хувь хүний карьер хөгжлийн боломжийг бий болгох асуудал юм.


Ажилтнуудаа хөгжүүлэх гол нөхцөл нь сургах асуудал байдаг. Банкны хувьд шинээр сонгогдсон ажилтнуудтай ажиллах, тэдгээрийг богино хугацаанд дасан зохицох боломжийг бүрдүүлэх зорилгоор дасан зохицох хөтөлбөр, ажлын байран дээрх сургалт, шинэ ажилтны сургалт зохион байгуулахын зэрэгцээ газар, нэгжүүдэд зайн сургалт, тайлант сургалт, шаталсан сургалт, хосолсон сургалт, ажил мэргэжлийн тэмцээн зэрэг илүү үр өгөөжтэй арга хэлбэрүүдийг өргөнөөр ашигладаг. Худалдаа, хөгжлийн банк байгууллагаараа суралцагч байгууллага тул манай хамт олны эгнээнд нэгдсэн ямар ч хүн сурч хөгжиж, мэргэшиж, байр сууриа олох бүрэн боломж байдаг.

ХХБ нь ирээдүйд аль ч шатанд ажиллах хүний нөөцөөр бүрэн хангагдсан ба одоо ажиллаж байгаа нийт ажилтнуудын 80-аас дээш хувь нь 35 хүртэл насын залуучууд, банкны ажилтнуудын дундаж нас 30 байна ХХБ нь ажилтнуудынхаа эрүүл мэнд, нийгмийн асуудлуудыг шийдэх өөрсдийн тогтсон бодлоготой байдаг. Энэхүү бодлогын хүрээнд хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцны болон цалингийн зээл авах боломжийг ажилтнуудаа олгох, ажлын бүтээмж, эдийн засгийн макро болон микро түвшний өөрчлөлтийг харгалzan ажилтнуудын цалингийн болон урамшууллын түвшинг нэмэгдүүлэх арга хэмжээг жил бүр авч ирсэн Спорт, урлаг, нийтийг хамарсан арга хэмжээнүүд зохион байгуулах, ажлын таатай нөхцлөөр хангах, төрийн болон салбарын шагналуудад ажилтнуудаа хамруулах, гадаад орнуудад банкны зардааар амруулах, эх орныхоо үзэсгэлэнт


Боловсролын түвшин



Ажилчид



газруудаар аялуулах зэрэг олон асуудлууд мөн энэ бодлогын хүрээнд шийдвэрлэгдэж байна. Зөвхөн 2011 онд нийт ажилтнуудын 11.6 хувь нь төрийн болон салбарын шагнал, урамшуулалд хамрагдсан бөгөөд 8-9 ажилтан тутмын нэг нь шагнагдсан байна.



## 2012 оны зорилт

"TDB соёл"-ыг нийт ажилтнуудын бахархал болгох, TDB-ийн үнэт зүйл болох ажилтан бүрийн ажилдаа хандах хандлага, сэтгэл ханамж, төлөвшлийг ямагт өндөрт байлгахад чиглэсэн иж бүрэн төслийг хэрэгжүүлэх.



# 2011 ОНЫ ХХБ-НЫ ХАМТЫН АМЖИЛТ, ОЛОЛТУУД

## ХХБ-НЫ СПОРТЫН АМЖИЛТ, ОЛОЛТУУД

Тэмцээний төрөл	Тэмцээний нэр	Зохион байгуулагдсан огноо	"TDB" амжилт
Сагсан бөмбөг	"Банкир-2011" тэмцээн	2011 оны 5-р сарын 10-наас 15-ны өдрүүдэд	2011 онд амжилтаа бататгаж, дахин эрэгтэй, эмэтгэй баг тамирчид тэргүүлж "Аваргын алтан цом"-ын эзэд боллоо.
Ширээний теннис	Арилжааны банк хоорондын ширээний теннисны аварга шалгаруулах 10 дахь удаагийн тэмцээн	2011 оны 11-р сарын 19	8 арилжааны банкны нийт 60 гаруй тамирчид өрсөлдсөнөөс байгууллагын дүнгээр манай баг тамирчид баг тамирчид тэргүүллээ.
Гар бөмбөг	Арилжааны банкуудын дунд уламжлал бологон зохиогддаг гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн	2011 оны 12-р сарын 5	Нийт 7 банкны баг тамирчид оролцсоноос ХХБ-ны баг тамирчид амжилттай оролцож эрэгтэй баг 2-р байр эзэлж, шилдэг довтлогчоор тодорлоо.
Хөл бөмбөг	Арилжааны банк хоорондын заалны хөл бөмбөгийн аварга шалгаруулах 4 дэх удаагийн тэмцээн	2011 оны 3-р сарын 26,27-ны өдрүүд	Банк санхүүгийн салбарын 12 баг оролцсоноос манай банкны баг тамирчид амжилттай оролцож, мөнгөн медаль хүртлээ.
	Арилжааны банк хоорондын хөлбөмбөгийн аварга шалгаруулах 9 дэх удаагийн тэмцээн	2011 оны 9-р сарын 11,10-ны өдрүүдэд	Манай баг тамирчид 2011 оны арилжааны банк хоорондын хөлбөмбөгийн аварга баг болж шилжин явах цомын эзнээр тодорлоо. Мөн шилдэг хаалгач, шилдэг довтлогчийн шагналыг тус тус хүртлээ.
Билльярд	Монгол банк болон арилжааны банк хоорондын Снукер билльярдын аварга шалгаруулах 11 дэх удаагийн тэмцээн	2011 оны 11-р сарын 28	Манай банкны тамирчид амжилттай оролцож 1 дүгээр байранд шалгарч шилжин явах цомын эзэд боллоо.



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ХХБ 2011 онд нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 1.5 тэрбум төгрөгийг дараах чиглэлүүдээр олгож, хамтран ажиллалаа.

Үүнд:

- > Монгол орон даяар буюу нийт 750 ЕБС-ийн хүүхэд багачуудын дунд зохиогдсон үндэсний хэмжээний “Монгол мөрөөдлийн баг” сагсан бөмбөгийн тэмцээнийг дэмжиж, ивээн тэтгэлээ.
- > Соёл урлаг, боловсролын салбарыг санхүүгийн хувьд байнга дэмжин, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлсээр ирсэн Худалдаа, хөгжлийн банк төгөлдөр хуурын гайхамшигийг олон улсад мэдрүүлэхэд хувь нэмрээ оруулан Хөгжим бүжгийн коллежийн 8-р ангийн сургач Г.Болормаад Парис хотноо зохиогдсон М.Магины нэрэмжит олон улсын төгөлдөр хуурын тэмцээн оролцоход нь санхүүгийн тусламж олголоо.
- > Төгөлдөр хуурын авьяаслаг охин Хөгжим бүжгийн коллежийн 9-р ангийн сургач Ч.Есөнхандийн төгөлдөр хуурын аялан тоглолтод нь санхүүгийн дэмжлэг үзүүллээ.
- > Өсвөрийн хөл бөмбөгийн тамирчдыг дэмжин “Дуулиан – 2020” заалны хөл бөмбөгийн тэмцээнийг дэмжин, санхүүгийн дэмжлэг үзүүллээ.
- > Норвеги улсын нийслэл Осло хотод зохион байгуулагдсан өсвөрийн “Norway cup 2011” хөл бөмбөгийн тэмцээнд оролцсон “Итгэл найдвар хөл бөмбөг” клубд санхүүгийн дэмжлэг үзүүлэн, ивээн тэтгэлээ.
- > Дипломат байгууллагуудын төлөөлөл, Элчин сайдын яамдууд болон Монгол улсад оршин суугаа гадаадын иргэдийн дунд зохиогдсон “Нөхөрлөл 2011” спортын анхдугаар тэмцээнийг ивээн тэтгэлээ.
- > Хөгжлийн бэрхшээлтэй тусгай дунд 29-р сургуулийн шинэ жилийн баярт оролzon, 380 гаруй хүүхдийг уламжлал ёсоор баярлуулав.
- > Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэлийн гүнээс урласан шинэ жилийн модны чимэглэлийн худалдааг дэмжин ажилласан.
- > Мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн ассоциаци-ийг дэмжин, санхүүгийн дэмжлэг үзүүллээ.
- > Олон улсын хэмжээний Introduction of Comprehensive Interbank Import Credit Facility with Korea Exim bank (4-р сар), Listing in Hong Kong (4 сард), Frontier Capital Raising Conference (6-р сард), Сингапур Монголын бизнесийн форум (6-р сард), Korea's economic success: Strategies, challenges and lessons for Mongolia (8 сард) болон Монгол улсад зохион байгуулагдсан уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчдын Discover Mongolia (9-р сард), Coal Mongolia 2011 (2-р сард), Metals Mongolia 2011 Forum (11-р сард), Монголын Эдийн Засгийн Форум (3-р сард), Mongolia Trade & Commodity Finance Conference (10-р сард), Монголд үйлдвэрлэв-2011, Авто экспо - 2011 үзэсгэлэн худалдаа зэрэг стратегийн ач холбогдол бүхий чуулган уулзалт, арга хэмжээнүүдийг ивээн тэтгэж, идэвхтэй оролцлоо.
- > Уул уурхайн салбарын мэргэжлийн шалгаруулалт болох Mining Journal Awards шалгаруулалтыг ивээн тэтгэж, оролцлоо.
- > Герман улсын Брауншвейг хотноо зохион байгуулагдсан бүжгийн спортын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол улсыг төлөөлөн оролцсон СЭЗДС-ийн Улаан Сарнай хамтлагийн зардлыг ивээн тэтгэж, санхүүгийн дэмжлэг үзүүллээ.
- > Монгол улсад Худалдааны салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан зохиогдсон “Худалдаа эрхлэгчдийн IV зөвлөгөөн”, “Гэрэл зургийн үзэсгэлэн”, “Үндэсний бөхийн барилдаан” зэрэг арга хэмжээг зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллалаа,
- > Дэлхийн Монгол туургатны өв соёлыг хамгаалах ажлын хүрээнд дэлхийд гайхагдсан Монгол ардын урлагийн шилдэг CD, DVD гаргах ажилд санхүүгийн дэмжлэг үзүүллээ.

# НОСТРО ДАНСТАЙ БАНКУУД

NO.	BANK NAME	LOCATION	SWIFT	CURRENCY	ACCOUNT NO
1	AGRICULTURAL BANK OF CHINA	HUHHOT, CHINA	ABOCCNBJ050	USD	05710114040000937
2	STANDARD CHARTERED BANK	NEW YORK, USA	SCBLUS33		3582023404001
3	CITIBANK N.A.,	NEW YORK, USA	CITIUS33		36202093
4	HSBC BANK USA N.A	NEW YORK, USA	MRMDUS33		000304298
5	ZAO UNICREDIT BANK	MOSCOW, RUSSIA	IMBKRUHM		001201442 USD 400202
6	KOREA EXCHANGE BANK	SEOUL, KOREA	KOEXKRSE		963-THR-287-01-1
7	CHINA CONSTRUCTION BANK	Huhhot, CHINA	PCBCCNBJNME		15014150509220100065
8	INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA	ERLIANHAOTE, CHINA	ICBKCNBNMA		0610040629200091076
9	OJSC SBERBANK, BAIKALSKY OFFICE	IRKUTSK, RUSSIA	SABRRU66		3011840718000000007
10	BAO SHANG BANK	BAO TOU, CHINA	BTCBCNBJXXX		001638896800060
11	OCBC BANK	SINGAPORE	OCBCSGSG		503-071441-301
12	JSC RUSSIAN AGRICULTURAL BANK	MOSCOW, RUSSIA	RUAGRUMM		3011840900000000008
13	JSC VTB Bank	MOSCOW, RUSSIA	VTBRRUMM		3011840855550000000
14	COMMERZBANK AG	FRANKFURT AM MAIN, GERMANY	COBADEFF		400878500800 USD
15	COMMERZBANK AG	FRANKFURT AM MAIN, GERMANY	COBADEFF	EUR	400878500801 EUR
16	ING BELGIUM NV/SA	BRUSSELS, BELGIUM	BBRUBEBB010		301-0104154-57-EUR
17	CREDIT SUISSE	ZURICH, SWITZERLAND	CRESCHZZ80A	CHF	0835-0993850-73-000
18	BANK OF TOKYO-MITSUBISHI UFJ LTD	TOKYO, JAPAN	BOTKJPJT	JPY	653-0439924
19	MIZUHO CORPORATE BANK LTD	TOKYO, JAPAN	MHCBJPJT		5793010
20	HSBC BANK PLC	LONDON, UNITED KINGDOM	MIDLGB22	GBP	00334567
21	KOREA EXCHANGE BANK	SEOUL, KOREA	KOEXKRSE	KRW	0963 FRW 001000043
22	AGRICULTURAL BANK OF CHINA, NEIMENGGU BRANCH	HUHHOT, CHINA	ABOCCNBJ050	CNY	05710101040021997
23	CHINA CONSTRUCTION BANK, ERLI-ANHAOTE SUB BRANCH	Huhhot, CHINA	PCBCCNBJNME		1500165840805250192
24	BAO SHANG BANK	Baotou, CHINA	BTCBCNBJXXX		001638896800010
25	Pudong Development Bank of Shanghai	Shanghai, China	SPDB CNSH XXX		99010154100000100
26	BANK OF CHINA (HONG KONG) LIMITED	Hong Kong, China	BKCHHKHH		012-875-60117544
27	INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA	ERLIANHAOTE, CHINA	ICBKCNBNMA		0610040629200090972
28	HSBC BANK AUSTRALIA LTD	SYDNEY, AUSTRALIA	HKBAAU2S	AUD	011-795630-041
29	Canadian Imperial Bank of Commerce	TORONTO, CANADA	CIBCCATT	CAD	1820613
30	ZAO UNICREDIT BANK	MOSCOW, RUSSIA	IMBKRUHM	RUB	001201442 RUR 400202
31	OJSC SBERBANK, BAIKALSKY OFFICE	IRKUTSK, RUSSIA	SABRRU66		3011810918000000002
32	JSC VTB Bank	MOSCOW, RUSSIA	VTBRRUMM		3011810455550000203
33	JSC RUSSIAN AGRICULTURAL BANK	MOSCOW, RUSSIA	RUAGRUMM		3011810800000000015
34	HONGKONG AND SHANGHAI BANKING CORPORATION LTD	AUCKLAND, NEW ZEALAND	HSBCNZ2A	NZD	040-013294-261
35	HANG SENG BANK LTD	HONG KONG	HASEHKHH	HKD	250-012796-001
36	OCBC BANK	SINGAPORE	OCBCSGSG	SGD	517-123360-001
37	NORDEA BANK AB	STOCKHOLM, SWEDEN	NDEASESS	SEK	39527705290 080502

# ХАМТЫН САНХҮҮЖИЛТАЙ ГОЛ ХАРИЛЦАГЧ БАНКУУД

Asian Development Bank	
ING Bank	
Korean Eximbank	
Commerzbank	
BNP Paribas	
UniCredit Bank	
VTB	
Industrial and Commercial Bank of China	
The Export-Import Bank of the Republic of China	
Russian Agricultural Bank	
Agricultural Bank of China	
Sumitomo Mitsui Banking Corporation	



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ТАНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ  
ТӨСЛИЙН ЗЭЭЛ,  
ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТИЙН  
ШИЛДЭГ БАНК



2011



2012



Монгол улсын

“ГАДААД ХУДАЛДААНЫ  
САНХҮҮЖИЛТИЙН  
ШИЛДЭГ БАНК”-аар  
2011, 2012 онд  
хоёр удаа шалгарлаа.



ДЭЛХИЙГ ТАНТАЙ ХОЛБОХ  
САНХҮҮГИЙН ГҮҮР



Хаяг: Жуулчны гудамж 7, Бага тойруу 12, Улаанбаатар хот, Монгол улс  
Утас: +976 11 312362, 326289      Факс: +976 11 327028      [www.tdbm.mn](http://www.tdbm.mn)

**[www.tdbm.mn](http://www.tdbm.mn)**

Төв салбар: Монгол улс, Улаанбаатар хот, Жуулчны гудамж-7, Бага тойруу-12  
Утас: +976 11 312362, 326289      Факс: +976 11 327028